



Европын Холбоо
санхүүжүүлэв



Food and Agriculture
Organization of the
United Nations

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ
“МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТой
УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН
ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТой УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Тайланг боловсруулсан зөвлөх баг:

Л.Мөнхзул, Багийн ахлагч

Д.Нямсүрэн, Зөвлөх

Б.Бүжинлхам, Зөвлөх

Г.Амаржаргал, Зөвлөх

Хянан тохиолдуулсан:

М.Санжаадорж, Сангийн Яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Энэхүү Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагаа, санхүүжилтийн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээг Европын холбооноос Монгол Улсын Засгийн газарт үзүүлж буй төсвийн дэмжлэгийн бүрэлдэхүүн “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” техник туслалцааны төслийн хүрээнд боловсруулав. Төслийг Европын холбооны санхүүжилтээр Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ), НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага хамтран хэрэгжүүлдэг.

НҮБХХ нь ядуурал, тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шударга бус байдлыг эцэслэх зорилго бүхий НҮБ-ын тэргүүлэх байгууллага юм. Дэлхийн 170 орны түншлэгчид болон мэргэжилтнүүдийн өргөн цар хүрээт хамтын ажиллагааны дүнд эх дэлхий, хүн бүрийн сайн сайхны төлөө хөгжлийн урт хугацааны, цогц шийдлийг бий болгоход улс үндэстнүүдийг дэмжин ажилладаг.

Ерөнхий зүйл: Энэхүү тайлан нь Европын холбоо (ЕХ)-ны санхүүжилтээр хэвлэгдсэн болно. Тайлангийн агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд ЕХ болон НҮБХХ-ийн албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй. Энэхүү тайланд ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт ЕХ, НҮБХХ хариуцлага хүлээхгүй болно. НҮБХХ-ийн зөвшөөрөлгүйгээр энэхүү хэвлэлийг худалдах, дахин хэвлэх, эсвэл ямар нэгэн ашиг олох хэрэгсэл болгохыг хориглоно.

Европын Холбоо бол Европ тивийн 27 тусгаар улсын эдийн засаг, улс төрийн нэгдэл юм. Тус Холбоо нь хүний эрхэм чанар, эрх чөлөө, ардчилал, эрх тэгш байдал, хууль дээдлэх ёс, хүний эрхийг түүний дотор цөөнхийн эрхийг дээдлэх үндсэн үнэт зүйлс дээр тулгуурлан байгуулагджээ. Өнөө цагт Европын Холбоо нь даян дэлхийн хүн бүрд хүртээмжтэй, нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулж байна.

© 2022 НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр.

Зохиогчийн бүх эрхийг хамгаалсан.

ISBN:



ННА (65.052)

ДАА (657)

ӨМНӨХ ҮГ

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ) нь “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” техникийн туслалцааны төслийг Европын Холбооны санхүүгийн дэмжлэгээр хэрэгжүүлж байна. Сангийн яам (СЯ) нь энэхүү төслийн нэгдүгээр бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагааг НҮБХХ-тэй хамтран хэрэгжүүлдэг.

СЯ-наас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хуваарилалтыг үр дүнд үндэслэсэн тогтолцоонд шилжүүлэх бодлогын зорилт дэвшүүлэн дотоодын зөвлөхүүдийг гэрээлэн ажиллуулж байна. Зөвлөхүүд төрөөс хэрэгжүүлж буй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтийн тогтолцооны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж энэхүү тайланг боловсруулсан. Тайланд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын хууль эрх зүйн орчин, хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээг оруулжээ. Түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого, зарлага, санхүүжилтийн зарчим, төрийн сангийн гүйлгээ болон сангийн төсвийн хуваарилалт, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээг санхүүжүүлэх жишиг зардалд шинжилгээ хийв. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэх хүний нөөц, санхүүжилтийн тогтолцоонд тулгамдаж буй асуудлуудад дүгнэлт хийж, цаашид хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөмж боловсрууллаа.

Энэхүү тайланг боловсруулахад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)-ны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ)-ын Санхүү, төлөвлөлтийн газрын дарга, мэргэжилтнүүд статистик мэдээлэл, санхүүжилттэй холбоотой тоо баримтаар хангаж ажилласанд талархлаа илэрхийлье.

САНГИЙН ЯАМНЫ ТӨСВИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАР

ӨМНӨХ ҮГ	3
ТОВЧИЛСОН ҮГ	7
1. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН	8
1.1. Хуулиуд	8
1.2. Урт ба дунд хугацааны бодлого	10
1.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, МБС-ын сангийн үйл ажиллагааг зохицуулсан журмууд	11
2. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ	13
2.1. Ажиллах хүч	13
2.2. Эдийн засгийн өсөлт ба ажилгүйдлийн түвшин	14
2.3. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт ба нийлүүлэлт	16
2.4. Их, дээд сургууль болон МБСБ төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт	18
3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГА	21
3.1. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоо	21
3.2. Дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага	27
3.3. Хорооны Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн	30
4. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	32
4.1. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	32
4.2. Хөдөлмөрийн эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, хэрэгжилт	37
4.3. ХЭД үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага, оролцогчид	40
4.4. ХЭД үйл ажиллагаатай холбоотой тулгамдсан асуудлууд	45
5. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САН	48
5.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын эх үүсвэр	48
5.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарцуулалт	49
5.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтийн зарчим, төрийн сангийн гүйлгээ	55
5.4. ХЭД сангийн төсвийн хуваарилалт	58
5.5. ХЭДС-аас ХЭД үйлчилгээ, арга хэмжээг санхүүжүүлэх жишиг зардал	61
5.6. ХЭДС-ийн санхүүгийн тайлагналт	63
5.7. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгодог жижиг зээл, санхүүгийн дэмжлэг	65
6. ДҮГНЭЛТ	68
7. ЗӨВЛӨМЖ	71
8. УУЛЗАЛТ, ЯРИЛЦЛАГА ХҮМҮҮСИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ	73
9. АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	75
10. ХАВСРАЛТ	77

Хүснэгт 1.	ХЭДС-г бүрдүүлэх, зарцуулахтай холбоотой журам	11
Хүснэгт 2.	МБС-ын санг бүрдүүлэх, зарцуулахтай холбоотой журам	12
Хүснэгт 3.	Ажиллагчдын тооны бууралт, хувиар	15
Хүснэгт 4.	Ажилгүйдлийн тэтгэмж авсан хүний тоо	15
Хүснэгт 5.	Ажиллах хүчний эрэлт ба ажиллагчдын тоо	17
Хүснэгт 6.	Аймаг, дүүргийн ХХҮГ/Х-ийн Хөдөлмөр эрхлэлтийн албаны ажилтны тоо (2020 он)	26
Хүснэгт 7.	Дүүргийн ХХҮХ-ийн Хөдөлмөр эрхлэлтийн албаны ажилтны тоо (2022.02)	27
Хүснэгт 8.	Ажилд зуучлах үйлчилгээний үүсэл	34
Хүснэгт 9.	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хэрэгжилт	35
Хүснэгт 10.	Нийтлэг үйлчилгээний санхүүжилтийн тариф	36
Хүснэгт 11.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр (2021-2022)	38
Хүснэгт 12.	ХЭД хөтөлбөрийн хэрэгжилтийн гүйцэтгэл	39
Хүснэгт 13.	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагууд	41
Хүснэгт 14.	Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагууд	42
Хүснэгт 15.	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагууд	43
Хүснэгт 16.	ХБИ-ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагууд	44
Хүснэгт 17.	Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагууд	45
Хүснэгт 18.	ХЭҮЗ-өөс ХЭД хөтөлбөрийг баталсан огноо	45
Хүснэгт 19.	ХЭДС-ийн зарцуулалт, зориулалтаар, сая төгрөгөөр	50
Хүснэгт 20.	ХЭД хөтөлбөр, нийтлэг үйлчилгээнд хамрагдсан хүний тоо	50
Хүснэгт 21.	Санхүүгийн дэмжлэгт 2021 онд зарцуулсан хөрөнгө, сая төгрөгөөр	52
Хүснэгт 22.	ХЭД хөтөлбөрүүдийн арга хэмжээний төсөв	53
Хүснэгт 23.	ХЭДС-ийн 2021 оны төсвийн хуваарь, гүйцэтгэл (мянган төгрөгөөр)	59
Хүснэгт 24.	Аймаг, дүүргийн төсвийн харьцуулалт - Хүн амын тоогоор	60
Хүснэгт 25.	Аймаг, дүүргийн төсвийн харьцуулалт - Ажилгүйдлийн тоогоор	60
Хүснэгт 26.	ХЭДС-аас олгосон жижиг зээлийн хэмжээ, төгрөгөөр	65

Зураг 1.	15 ба түүнээс дээш насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо, мянган хүнээр 2021 оны II улирал	14
Зураг 2.	ДНБ болон ажилгүйдлийн түвшний хамаарал, хувиар	14
Зураг 3.	2020 оны ажиллах хүчний эрэлт, салбараар, хувиар	16
Зураг 4.	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	18
Зураг 5.	МБСБ-ыг төгсөгчдийн тоо	19
Зураг 6.	Их, дээд сургууль төгсөгчдийн мэргэжлийн дагуух хөдөлмөр эрхлэлт, 2020 он	19
Зураг 7.	МБСБ төгсөгчдийн мэргэжлийн дагуух хөдөлмөр эрхлэлт, 2020 он	20
Зураг 8.	Төгсөгчдийн мэргэжлээрээ ажиллахгүй байгаа шалтгаан	20
Зураг 9.	ХНХЯ-ны харъяа байгууллагууд	22
Зураг 10.	Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын асуудал хариуцсан ХНХЯ-ны нэгж, мэргэжилтнүүд	24
Зураг 11.	ХХҮХ-ийн Хөдөлмөр эрхлэлтийн алба (ХЭА)-ны үйлчилгээний танхим	28
Зураг 12.	Дүүргийн ХХҮХ-ийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний танхим	29
Зураг 13.	Хорооны мэргэжилтний ажлын байрны чиг үүрэг	30
Зураг 14.	Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааны SWOT шинжилгээ	40
Зураг 15.	ХЭДС-ийн орлогын гүйцэтгэл, тэрбум төгрөгөөр	48
Зураг 16.	ХЭДС-ийн орлогын төлөвлөгөө ба гүйцэтгэл, тэрбум төгрөгөөр	49
Зураг 17.	ХЭДС-ийн орлогын гүйцэтгэл, сараар, сая төгрөгөөр	49
Зураг 18.	ХЭДС-ийн зарлагын төсөв, тэрбум төгрөгөөр	50
Зураг 19.	ХЭД хөтөлбөрийн төсөв, нийт хөтөлбөрийн төсөвт эзлэх хувиар, 2017-2021 он	51
Зураг 20.	ХЭД хөтөлбөрийн нийт төсөвт Санхүүгийн дэмжлэгийн эзлэх хувь, 2017-2021	54
Зураг 21.	ХЭДС-ийн зарлагын төсвийн гүйцэтгэл, тэрбум төгрөгөөр	54
Зураг 22.	Мэргэжлийн сургалт, давтан сургалт зохион байгуулах үйл явц	56
Зураг 23.	ХЭДС-аас анхан шатны нэгжүүдэд санхүүжилт хийх үйл явц	58
Зураг 24.	Арилжааны банкаар дамжуулан жижиг зээл олгох процесс	66

ААН	Аж ахуйн нэгж
АМЧБ	Ажил мэргэжлийн чиг баримжаа
ДБ	Дэлхийн банк
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ЗГ	Засгийн газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
НҮБХХ	Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
НХЭГ	Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар
МБС	Мэргэжлийн боловсрол, сургалт
МБСБ	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага
МУ	Монгол Улс
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
СЯ	Сангийн яам
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ТББ	Төрийн бус байгууллага
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХБХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
ХБХХЕГ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
ХНХ	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал
ХНХСИ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХТХ	Хөдөлмөрийн тухай хууль
ХХДХ	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХҮХ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
ХЭА	Хөдөлмөр эрхлэлтийн алба
ХЭД	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХЭҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага
ЭХМК	Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс

1.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсад Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой дараах хуулиуд байдаг. Үүнд:

Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой Хөдөлмөрийн тухай (1999, 2021),

Ажиллах хүч, гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай (2001),

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай (2011),

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай (2002),

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай (2008)

1.1. Хуулиуд

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль 2001 онд батлагдсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг уян хатан төлөвлөж хэрэгжүүлэх, хуулийг хэрэгжүүлэхэд өмнө гарч байсан зарим хүндрэл бэрхшээлийг шийдэх зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2011 онд Улсын их хурал (УИХ)-аас баталсан. Түүнчлэн Төсвийн тухай хууль, Засгийн газрын бүтцийн тухай хууль, холбогдох бусад хуулиудад оруулсан нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан 2012, 2014, 2016 онуудад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

ХНХЯ-наас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг шинэчлэн боловсруулахаар ажиллаж, хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар 2018 онд батлуулжээ. Хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах үзэл баримтлалд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төрөл, хэлбэр, арга хэмжээ, үйлчилгээг боловсронгуй болгож, Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын 181, 88 дугаар конвенцид нийцүүлэх, “халамжаас хөдөлмөр эрхлэлт рүү” гэсэн зарчмын агуулгыг тусгах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын эх үүсвэр нь

гадаадын ажиллах хүч, мэргэжилтний ажлын байрны төлбөрийн орлогоос шууд хамаарч байгааг өөрчилж, өөр бусад эх үүсвэрээс, ялангуяа улсын төсөв болон ажилгүйдлийн даатгалын сантай уялдуулах зохицуулалтыг хийхээр тусгажээ. Түүнчлэн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн ойрын, дунд, хэтийн хугацааны судалгааг холбогдох аргачлалын дагуу хийж, дүн, мэдээг нийтэд түгээх замаар зөв мэргэжил сонголтыг дэмжих харилцааны зохицуулалтыг хуулийн төсөлд тусгахаар төлөвлөжээ.

АЖИЛЛАХ ХҮЧ ГАДААДАД ГАРГАХ, ГАДААДААС АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТЭН АВАХ ТУХАЙ ХУУЛЬ

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч мэргэжилтэн авах тухай хуулийг 2001 онд УИХ-аас баталснаас хойш зарчмын өөрчлөлт оруулаагүй байсан. ХНХЯ-наас уг хуулийг "Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль" болгон шинэчлэн найруулж, төслийг УИХ-д өргөн барьсан. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аар хэлэлцэж, 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдөр батлаад байна. Шинэчилсэн найруулгад ажил олгогч эхний ээлжинд дотоодоос ажилтан авч ажиллуулах, гадаадаас ажиллах хүч авсан тохиолдолд монгол ажилчдыг сургах, ажиллуулах чиг үүргийг бий болгох, албан бус зуучлалыг зогсоох, гадаадаас ажилтан авах хувь хэмжээ /квот/-ний тогтолцоог өөрчлөх, олон улсын гэрээ конвенцийн зарчимд нийцүүлэн хуулийн зүйл заалтыг сайжруулах, шилжих хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтыг үндэсний хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэлд тулгуурлан, нэгдмэл байдлаар зохицуулах зэрэг зарчмын өөрчлөлтийг тусгасан байна.

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийг 2002 онд баталснаар мэргэжлийн боловсрол, сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, сургалтын агуулга, арга зүйг сайжруулах, суралцагчдын ур чадварыг нэмэгдүүлэх, төгсөгчдийг ажлын байранд зуучлах, төр хувийн хэвшлийн түншлэлийн эрх зүйн орчин бүрдсэн. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийг 2009 онд шинэчлэн найруулж, хуульд 2012, 2015, 2016 онд нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

ХНХЯ-наас Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, УИХ-д 2021 онд өргөн мэдүүлсэн боловч буцаан татсан. 2022 оноос эхлэн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудыг ХНХ-ын сайдаас Боловсрол, соёл, шинжлэх ухаан (БСШУ)-ы сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлсэн.

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Хөдөлмөрийн тухай хууль 1999 онд шинэчлэгдэн батлагдаж, хүчин төгөлдөр болсноос хойш нийт 24 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. Хөдөлмөрийн тухай хууль нь шилжилтийн үеийн хөдөлмөрийн харилцааг зохицуулахад өөрийн үүргээ хангалттай биелүүлж ирсэн хэдий ч зах зээлийн эдийн засгийн өнөөгийн нөхцөлд тавигдаж байгаа хөдөлмөрийн харилцааны шаардлагыг бүрэн хангаж чадахгүй болсон. Иймд Хөдөлмөрийн тухай хуулийн хамрах хүрээг өргөжүүлэх, хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөрийн харилцааны өнөөгийн байдал, олон улсын хэм хэмжээ, чиг хандлагад нийцүүлэн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газраас 2020 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-аас 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр баталсан бөгөөд 2022 оноос эхлэн хүчин төгөлдөр мөрдөж байна.

1.2. Урт ба дунд хугацааны бодлого

ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО (2016-2026)

МУ-ын Засгийн газар (ЗГ)-ын 2016 оны 320 дугаар тогтоолоор Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого (2016-2026)-ыг баталсан. Уг урт хугацааны бодлогын зорилго нь хүн амын хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлж, ажиллах хүчний мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэн зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ядуурлын түвшинг бууруулахад чиглэнэ гэжээ. Бодлогын баримт бичигт 33 арга хэмжээг тодорхойлж, арга хэмжээний хэрэгжилтийг хянах 14 шалгуур үзүүлэлтийг тусгажээ. Энэхүү урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдаагүй байна.

"АЛСЫН ХАРАА 2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа 2050" МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлогод хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой бодлогыг 2050 он хүртэл 3 үе шаттай хэрэгжүүлэхээр тусгасан. Энэ бодлогод хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилтыг дэвшүүлсэн. Ингэхдээ I үе шатанд (2021-2030) хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангах, хэрэгцээнд суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бэхжүүлэх, II үе шатанд (2031-2040) бүтээмжид суурилсан, хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бэхжүүлэх, III үе шатанд (2041-2050) мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, хүн бүр ажилтай, орлоготой болох орчин, нөхцөлийг бүрдүүлэхээр үр дүнг тодорхойлжээ. Түүнчлэн Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр дараах зорилтууд тусгагдсан байна. Үүнд:

"Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс"

"...2.5.9 Орлого багатай өрхийн ажил эрхэлдэггүй насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

2.5.10 Томоохон бүтээн байгуулалт, үндэсний болон орон нутгийн хөгжлийн зорилт, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээтэй уялдуулан мэргэжлийн боловсрол, сургалтыг төрөлжүүлнэ.

2.5.1 Мэргэжлийн боловсрол, сургалтын шинэ хотхон, дадлагын бааз байгуулж, санхүүгийн бие даасан байдлыг хангана.

2.5.14 Бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн үр дүнд болон хувийн хэвшил, жижиг, дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар 150 мянган ажлын байр шинээр бий болгоно.

2.5.15 Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа монгол иргэдийг дэмжих, эх орондоо эргэн ирж ажиллаж хөдөлмөрлөхөд дэмжлэг үзүүлэх хөдөлмөрийн бирж бий болгоно."

УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (2020-2025)"-д хөдөлмөр эрхлэлттэй холбоотой дараах зорилтуудыг тусгасан байна.

“2.6 Хэрэгцээнд суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бэхжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангана.

2.6.2. ажилгүйдлийн даатгалын тогтолцоо боловсронгуй болж, хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг үр дүнд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлэн ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.6.3. оюуны хөдөлмөрийг дэмжсэн цахим, зайн ажлын байрыг нэмэгдүүлнэ.

2.6.4. албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулна.”

1.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, МБС-ын сангийн үйл ажиллагааг зохицуулсан журмууд

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (ХЭДС)-гийн үйл ажиллагааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулахаас гадна хүснэгт 1-д дурдсан журмуудаар зохицуулж байна.

Хүснэгт 1. ХЭДС-Г БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ЖУРАМ

Журмын нэр	Баталсан огноо	Цаашид авбал зохих арга хэмжээ
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам	ЗГ-ын 2011 оны 375 дугаар тогтоол	Төсвийн тухай хууль, бусад хуультай нийцүүлэн журамд өөрчлөлт оруулах, зарим зохицуулалт нэмэх шаардлагатай
“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”	ЗГ-ын 2021 оны 340 дүгээр тогтоол	Өмнөх журмыг шинэчлэн энэ журмыг баталсан. Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн хэмжээг нэмэгдүүлж, хугацааг уртасгасан. Харин санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөөгүй үед үүсэх өр, авлагыг хэрхэн барагдуулах талаарх зохицуулалтууд хангалтгүй байна.
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/96 тоот тушаал	Үйлчилгээ, хөтөлбөрийн арга хэмжээний өртгийг дахин тооцох шаардлагатай
Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт (тарифаар тооцож) олгох журам	Хөдөлмөрийн сайдын 2014 оны А/123 тоот тушаал	Журмын зохицуулалтыг илүү сайжруулах шаардлагатай. Жишээ нь, ХБИ хувийн биржээр зуучлуулан ажилд орсон тохиолдолд ажил олгогчид нь 12 сарын цалингийн дэмжлэг үзүүлдэггүй. Зөвхөн аймаг, дүүргийн ХХҮГ/Х-ээр зуучлуулан ажилд орсон тохиолдолд ажил олгогчийг дэмжих урамшуулалд хамрагддаг.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаа, орлого бүрдүүлэлт, зарцуулалт болон тулгарч буй асуудлуудын талаар хойно дэлгэрэнгүй авч үзэх болно.

ХНХЯ нь Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага (МБСБ)-уудад үйл ажиллагааны зөвшөөрөл олгох, чанарын магадлан итгэмжлэл хийх, сургалтын хөтөлбөр, хөтөлбөрийн стандартуудыг батлах зэрэг гол үйл ажиллагааг 2012 оноос хойш эрхлэн гүйцэтгэж ирсэн. Харин 2022 оноос эхлэн МБСБ-уудыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан (БСШУ)-ны сайдын харъяанд шилжүүлэхээр УИХ-аас шийдвэрлээд байна. МБС-ыг дэмжих сангаас төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын тогтмол зардал, сурагчийн дотуур байрны нийт зардал, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр нэг сурагчид ногдох хувьсах зардал болон суралцагчийн тэтгэлгийн зардал зэргийг санхүүжүүлж байна. МБС-ыг дэмжих сангийн үйл ажиллагааны зохицуулалттай холбоотой журмыг хүснэгт 2-т жагсаав.

Хүснэгт 2. МБС-ЫН САНГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ЖУРАМ

Журмын нэр	Баталсан огноо	Тайлбар
“Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”	ЗГ-ын 2011 оны 117-р тогтоол (хэт ерөнхий журам)	Хэт ерөнхий зохицуулалт бүхий журам, цаашид Төсвийн тухай хуульд нийцүүлэн шинэчлэх шаардлагатай
“Зардлын дундаж норматив батлах тухай” (суралцагчийн ба дотуур байрны хувьсах зардал)	ЗГ-ын 2012 оны 94-р тогтоол (өртөг тооцох шаардлагатай)	
“Хувьсах зардлын дундаж норматив, санхүүжүүлэх аргачлал батлах тухай”	ЗГ-ын 2016 оны 276 дугаар тогтоол	Журмын зохицуулалтыг илүү сайжруулах шаардлагатай. Жишээ нь, ХБИ хувийн биржээр зуучлуулан ажилд орсон тохиолдолд ажил олгогчид нь 12 сарын цалингийн дэмжлэг үзүүлдэггүй. Зөвхөн аймаг, дүүргийн ХХҮГ/Х-ээр зуучлуулан ажилд орсон тохиолдолд ажил олгогчийг дэмжих урамшуулалд хамрагддаг.
“Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, албан хаагчдад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох журам”	ЗГ-ын 2017 оны 346 дугаар тогтоол	МБСБ-уудад олгох хувьсах зардлын өртгийг шинэчлэн тогтоохоор холбогдох газар, төслүүд ажиллаж байна.



2.

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1. Ажиллах хүч

2021 оны 2 дугаар улирлын байдлаар ажиллах хүчний тоо 1207.0 мянган хүн буюу хөдөлмөрийн насны хүн амын 56.8 хувь бол ажиллах хүчнээс гадуур 917.0 мянга хүн (43.2%) байна (Зураг 1). Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ажиллах хүч 61.9 (4.9%) мянган хүнээр буурч, ажиллах хүчнээс гадуурх хүн ам 62.4 (7.3%) мянгаар өссөн байна.

Ажиллах хүчний 1105.7 мянга (91.6%) нь цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж байгаа ажиллагчид, 101.3 мянга (8.4%) нь хөдөлмөрийн дутуу ашиглалтын нэг бүлэг болох ажилгүй хүн буюу цалин хөлс, орлого олох ажилгүй, сүүлийн 30 хоногт ажил идэвхтэй хайсан болон тухайн 7 хоногтоо ажил хийхэд бэлэн байгаа хүн байна.


Харин ажиллах хүчнээс гадуурх хүн амын 71.8 (7.8%) мянга нь боломжит ажиллах хүч (цалин хөлс, орлого олох ажилгүй, сүүлийн 30 хоногт ажил идэвхтэй хайсан эсвэл тухайн 7 хоногтоо ажил хийхэд бэлэн байгаа хүн) байна. Боломжит ажиллах хүчний бүлэг нь тухайн сум, орон нутагт нь ажлын байр бий болох эсвэл ажил хийх нөхцөл нь бүрдвэл хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцож эхлэх, ажиллах хүчний эгнээнд шилжихэд бэлэн байгаа хүн ам юм. Боломжит ажиллах хүчний бүлгийг ажиллах хүчин дээр нэмж өргөн утгаар нь өргөтгөсөн ажиллах хүч гэж авч үздэг.

Ажиллах хүч өмнөх оны мөн үеэс буурахад ажиллагчид 79.5 мянга буюу 6.7 хувиар буурч, ажилгүй хүн 17.5 мянга буюу 20.9 хувиар өссөн нь нөлөөлжээ.



Зураг 1. 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ОРОЛЦОО, МЯНГАН ХҮНЭЭР


2021 оны II улирал



2.2. Эдийн засгийн өсөлт ба ажилгүйдлийн түвшин

Сүүлийн 10 гаруй жилд ажилгүйдлийн түвшин дунджаар 8-10 орчим хувьтай байсан бол эдийн засгийн өсөлтийн хэмжээ -4.4 хувиас 17.3 хувийн хооронд хэлбэлзсэн. Окуны хуулиар ажилгүйдлийн түвшин 1 хувиар буурахад эдийн засаг 2 хувиар өсдөг гэсэн ерөнхий таамаг байдаг. Монгол Улсын хувьд ажилгүйдлийн түвшний өөрчлөлт ба ДНБ-ий өсөлт, бууралтын хооронд уялдаа, хамааралгүй байна (Зураг 2). Энэ нь бүтцийн ажилгүйдлийн түвшин өндөр буюу хөдөлмөрийн зах зээлийн бүтцэд үндсэн асуудал байгаатай холбоотой. Нөгөө талаас, эдийн засгийн өсөлтөд уул уурхай, боловсруулах салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн өсөлт голлох нөлөө үзүүлдэг бөгөөд эдгээр салбар нь ажиллах хүчний шингээлт хамгийн бага байдагтай холбоотой байна.










Зураг 2. ДНБ БОЛОН АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШНИЙ ХАМААРАЛ, ХУВИАР



Ковид-19 цар тахлын нөлөөгөөс үүдэн 2020 онд Монгол Улсын эдийн засаг 1990-ээд оноос хойш тохиолдож байгаагүйгээр буурсан боловч ажилгүйдлийн түвшин мөн онд 10 хувиас 7 хувь хүрч буурсан үзүүлэлттэй байна.

Цар тахлын үед хөл хорио тогтоох арга хэмжээг удаан хугацаанд хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор дэлхийн ихэнх улсад эдийн засаг нь агшиж, ажилгүйчүүдийн тоо нэмэгдсэн. 2019-2020 оны цар тахлын нөлөөг 2007-2008 оны дэлхийн эдийн засаг, санхүүгийн хямралын үетэй харьцуулсан тайланг ОУХБ, Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-аас хамтран 2020 онд гаргасан¹. Уг тайланд Ковид-19 цар тахлын эхэн үе болох 2019 оны IV улирлаас 2020 оны II улирлын хооронд дэлхийн зарим улсад ажиллагчдын тоо хэрхэн буурсныг харуулжээ. (Хүснэгт 3) Ажиллагчдын тооны бууралтад ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн, гэрээгээ үргэлжлүүлэн сунгаагүй хүний тоог оруулсан байна.

Хүснэгт 3. АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ БУУРАЛТ, ХУВИАР

		2020 I/ 2019 IV	2020 оны II улирал	Дэлхийн эдийн засгийн хямрал
	МЕКСИК	-36%	-20%	-3%
	ИТАЛИ	-35%	-4%	-2%
	ТУРК	-26%	-24%	-2%
	КАНАД	-27%	-5%	0
	АНУ	-20%	-9%	-4%
	ИХ БРИТАНИ	-21%	-16%	-2%
	АВСТРАЛИ	-11%	-2%	2%
	БНСУ	-7%	-4%	-1%
	ЯПОН	-8%	-3%	-2%

Эх сурвалж. ОУХБ ба ЭХАХБ, 2020

Цар тахлын үеийн нөлөө нь 2007-2008 онд тохиолдсон дэлхийн эдийн засаг, санхүүгийн хямралтай харьцуулахад улс орнуудын эдийн засагт хүнд цохилт болж, олон ажлын байрыг үгүй болгожээ.

2017 оноос хойш ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авсан хүний тоог хүснэгт 4-т харуулав. Сүүлийн 5 жилийн хугацаанд ажилгүйдлийн тэтгэмж авсан хүний тоо харьцангуй тогтвортой байсан ба 2021 оны эцэст ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо өмнөх оныхтой харьцуулахад бага зэрэг өсөх хандлагатай байна. Энэ нь манай улсын хувьд 2021 оны эхний хагаст хатуу хөл хорио тогтоох арга хэмжээг хэрэгжүүлснээс эдийн засгийн үйл ажиллагаа илүү саарсантай холбоотой байж болно.

Хүснэгт 4. АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ АВСАН ХҮНИЙ ТОО

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021
Ажилгүйдлийн тэтгэмж авсан хүний тоо	21,131	21,935	23,033	21,374	26,145
Ажилгүйдлийн тэтгэмж олгосон мөнгөн дүн (сая.төг)	34,692.8	34,364.3	43,549.8	50,228.1	57,016.7

Эх сурвалж. YCX, 2021

¹ The impact of the COVID-19 pandemic on jobs and incomes in G20 economies, ILO-OECD paper, 2020

Монгол Улсын хувьд дэлхийн зарим улсуудтай харьцуулахад цар тахлын үед ажилгүйдлийн түвшин, ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоонд төдийлөн өөрчлөлт ороогүй нь хэд хэдэн шалтгаантай байж болно.

Үүнд **i)** эдийн засгийг дэмжих зорилгоор МУ-ын ЗГ-аас хүн ам, аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг хойшлуулах, хөнгөлөх, хөнгөлөлттэй зээл олгох, борлуулалтын орлого нь буурсан аж ахуйн нэгжүүдэд ажилтан бүрийн тоогоор цалингийн татаас олгох зэрэг цогц арга хэмжээг хэрэгжүүлсэн. Жишээ нь, 2020 онд 7,284 аж ахуйн нэгжийн 220,852 ажилтанд давхардсан тоогоор 44.2 тэрбум төгрөгийн цалингийн татаас олгосон байна²; **ii)** цар тахлын нөлөө нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, өрхийн аж ахуй, бичил, жижиг бизнес эрхлэгчдэд хүндээр тусч үйл ажиллагаагаа зогсоож, орлогоо алдахад хүргэсэн боловч тэд ихэвчлэн албан бус салбарт хамаардаг, эсхүл сайн дурын нийгмийн даатгалд хамрагддаг хэдий ч ажилгүйдлийн даатгалд хамрагддаггүй учраас ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүсдэггүйтэй холбоотой.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт (ХНХСИ)-ээс гаргасан тайланд³ 2021 оны 3-р улирлын байдлаар албан журмын даатгуулагчид өмнөх оны мөн үеэс 35.8 мянга буюу 4.1 хувиар өссөн бол сайн дурын даатгуулагчид өмнөх оны мөн үеэс 25.1 мянга буюу 14.5 хувиар буурсан нь Ковид-19 цар тахал албан салбараас илүү албан бус салбарт нөлөөлж байна гэж дурдсан байна.

2.3. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт ба нийлүүлэлт

ХНХСИ-ээс жил бүр гаргадаг “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа”-гаар богино хугацааны ажиллах хүчний эрэлтийг ажил мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар тодорхойлдог. 2019 онд хийсэн Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаагаар 2020 онд 72.7 мянган ажлын байрны эрэлт хөдөлмөрийн зах зээлд бий болно гэж тооцоолсон. Энэ эрэлтийн 81.3 хувь нь байнгын ажлын байр байх ба 59.8 хувь нь шинэ ажлын байр, 40.2 хувь нь сул ажлын байрны эрэлт гэж таамагласан.

Зураг 3. 2020 ОНЫ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ЭРЭЛТ, САЛБАРААР, ХУВИАР



² Засгийн газрын зүгээс Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай. СЯ-ны тайлан, 2021 он
³ МУ-ын Хөдөлмөрийн зах зээл дэх “Ковид-19” цар тахлын нөлөө (2021 оны III улирал), ХНХСИ

Ажиллах хүчний эрэлтийг салбараар харахад бөөний болон жижиглэн худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт хамгийн их эрэлт бий болох хандлагатай байсан. Хэдийгээр ажиллах хүчний эрэлтийн 20.0 хувийг барилгын салбарын эрэлт дангаараа бүрдүүлж байсан ч 2019 онтой харьцуулахад 27.7 пунктээр буурсан үзүүлэлт байв.

Хүснэгт 5. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ЭРЭЛТ БА АЖИЛЛАГЧДЫН ТОО

Салбар	Ажиллах хүчний эрэлт, 2020	Ажиллагчдын тоо, 2019	Ажиллагчдын тоо, 2020	Ажиллагчдын тооны өөрчлөлт
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	16,648	160,405	166,590	6,185
Барилга	14,540	68,847	77,279	8,432
Боловсруулах үйлдвэрлэл	7,415	90,378	89,722	-656
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	4,435	20,163	18,050	-2,113
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	3,999	36,280	29,991	-6,289
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	3,635	44,376	60,189	15,813
Уул уурхай, олборлолт	2,981	57,923	51,575	-6,348
Боловсрол	2,763	96,108	110,735	14,627
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2,472	18,031	11,612	-6,419
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	2,254	290,160	276,455	-13,705
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	2,254	24,547	29,752	5,205
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1,963	61,123	66,541	5,418
Мэдээлэл, холбоо	1,599	13,019	18,830	5,811
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1,527	24,257	29,355	5,098
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	1,454	10,786	8,314	-2,472
Бусад	2,690	129,755	117,905	-11,850
НИЙТ	72,627	1,146,158	1,162,895	16,737

Эх сурвалж. ҮСХ, ХНХСИ

Дээрх хүснэгт 5-д Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгааны үр дүн болон ҮСХ-ноос мэдээлсэн нийт ажиллагчдын тоог харуулав. Ажиллагчдын тоог салбаруудаар задалж үзэхэд 66,589 хүнээр нэмэгдсэн боловч, зарим салбарын ажиллагчдын тоо 49,852 хүнээр буурснаар 2020 оны эцэст нийт ажиллагчдын тоо зөвхөн 16,737 хүнээр нэмэгджээ. Судалгаагаар 2020 онд 72,627 ажиллах хүчний эрэлт үүснэ гэж таамагласантай ойролцоо буюу ажиллагчдын тоо нийт 66,589 хүнээр нэмэгдсэн байна. Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа, боловсрол, үйлчилгээ, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, мэдээлэл холбоо,

даатгалын салбарт ажиллагчдын тоо таамагласнаас илүү нэмэгдсэн байна. Хөдөлмөрийн зах зээлд дээд боловсролын ажил мэргэжлийн эрэлтээс илүү МБСБ-аар бэлтгэгддэг ажил мэргэжлийн эрэлт өндөр байна. Тухайлбал, тогооч, зөөгч, гагнуурчин зэрэг ажил мэргэжил жил бүр эрэлттэй ажил мэргэжилд тооцогдож байна.⁴ Энэ нь мөн эдгээр ажил мэргэжил дэх хөдөлмөр эрхлэлт төдийлөн тогтвортой бус байдагтай холбоотой.


Харин дээд боловсрол шаардах ажил мэргэжлээс нягтлан бодогч, сувилагчийн эрэлт өндөр байхын зэрэгцээ ажиллах хүчний хомсдолд багагүй хувийг эзэлдэг байна. Нэг талаас жил бүр 100 гаруй мянган хүн ажилгүй байгаа боловч нөгөө талаас хөдөлмөрийн зах зээлд сүүлийн 10 жилийн хугацаанд жилд 57.6-80.1 мянган ажиллах хүчний эрэлт үүсч, сүүлийн 8 жилийн хугацаанд дунджаар 16.6 мянган ажиллах хүчний хомсдолд жил бүр оржээ.⁵ Хөдөлмөрийн дотоод зах зээлд ажилгүй хүний тоо өндөр боловч гадаад ажиллах хүчийг Монгол Улс авч ажиллуулсаар байна. Ийнхүү дотоодын хөдөлмөрийн зах зээлд мэргэжил, боловсролтой ажилгүйчүүдийн тоо өндөр байгаа ч гадаадаас ажиллах хүч импортолж, аж ахуйн нэгжүүд ажиллах хүчний хомсдолд орж байгаа нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт тохирохгүй зөрүүтэй байгааг илтгэж байна.

2.4. Их, дээд сургууль болон МБСБ төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт

ХНХСИ-ээс гаргасан 2021 оны II улирлын Хөдөлмөрийн зах зээлийн тойм судалгаанд 2015-2016 оны хичээлийн жилд их, дээд болон МБСБ-ыг төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг мөшгих судалгааны дүнг оруулжээ. Уг судалгаанд 44.9 мянган төгсөгчдийг төлөөлүүлэн 4,909 төгсөгчийг сонгон 2017 оноос эхлэн хамруулсан бөгөөд 2020 онд дээрх төгсөгчдийн 3,671 төгсөгчөөс мэдээлэл цуглуулжээ.

Судалгааны дүнгээр нийт төгсөгчдийн 74.8 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаагаас их, дээд сургууль төгсөгчдийн 76.9 хувь нь, МБСБ төгсөгчдийн 71.5 хувь нь тус тус хөдөлмөр эрхэлж байна. (Зураг 4)

Зураг 4. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН



Эх сурвалж. "Хөдөлмөрийн зах зээлийн тойм" 2021 оны II улирал, ХНХСИ


Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл 11.9 хувь нь боловсролын, 11.3 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны, 10.6 хувь нь үйлчилгээний, 9.2 хувь нь барилгын салбарт түлхүү ажиллаж байна.

⁴ Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа, ХНХСИ, 2020

⁵ Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа, ХНХСИ, 2020

Харин ХНХЯ-наас гаргасан тайланд МБСБ-ыг төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин дээрх судалгааны дүнгээс доогуур буюу 51.5-62.3 хувьтай байна. (Зураг 5)


Зураг 5. МБСБ-ЫГ ТӨГСӨГЧДИЙН ТОО



Эх сурвалж. ХНХЯ, Мэргэжлийн боловсролын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 2021

Их, дээд сургууль төгсөгчдийн 66.5 хувь нь мэргэжлийн дагуу хөдөлмөр эрхэлж байна гэсэн судалгааны дүн гарсан. (Зураг 6)


Зураг 6. ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ ТӨГСӨГЧДИЙН МЭРГЭЖЛИЙН ДАГУУХ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, 2020 ОН



Эх сурвалж. "Хөдөлмөрийн зах зээлийн тойм" 2021 оны II улирал, ХНХСИ

Харин МБСБ төгсөгчдийн зөвхөн 51 хувь нь эзэмшсэн мэргэжлийн дагуу хөдөлмөр эрхэлж байгаа нь их, дээд сургууль төгсөгчдийнхөөс доогуур үзүүлэлт болж байна. (Зураг 7)

Зураг 7. МБСБ ТӨГСӨГЧДИЙН МЭРГЭЖЛИЙН ДАГУУХ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, 2020 ОН




Эх сурвалж. "Хөдөлмөрийн зах зээлийн тойм" 2021 оны II улирал, ХНХСИ

Өөрөөр хэлбэл, жилд дунджаар 20 орчим мянган суралцагч МБСБ-ыг төгсдөг ба тэдний 63 орчим хувь нь ажлын байртай болсноос 51 хувь нь мэргэжлээрээ ажиллана гэж тооцвол нийт төгсөгчийн 32 орчим хувь буюу дөнгөж 6.4 мянган төгсөгч нь мэргэжлээрээ ажиллах магадлалтай байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.

Хөдөлмөр эрхэлж байгаа ч мэргэжлээрээ ажиллахгүй байгаа төгсөгчдийн шалтгааныг тодруулахад тухайн эзэмшсэн мэргэжлийн ажлын байр хомс, олдохгүй байгаа, цалин бага, мэргэжлээрээ ажиллах сонирхол байхгүй, ажилласан жилийн туршлага шаарддаг учраас, одоо ажиллаж буй ажилдаа сэтгэл ханамжтай, өөрийнхөө сонирхлоороо ажиллаж байгаа, хувийн болон гэр бүлийн бизнес эрхэлж байгаа зэрэг түлхүү шалтгаантай байна. Мэргэжлээрээ ажиллах сонирхолгүй, мэргэжилдээ сэтгэл ханамжгүй, өөр мэргэжлээр ажиллаж байгаа ч тухайн ажилдаа сэтгэл ханамжтай байгаа төгсөгчдөөс харахад нийт төгсөгчдийн 10 гаруй хувьд нь мэргэжил сонголтын алдаа байгаа нь харагдаж байна.

Зураг 8. ТӨГСӨГЧДИЙН МЭРГЭЖЛЭЭРЭЭ АЖИЛЛАХГҮЙ БАЙГАА ШАЛТГААН

■ ИДС төгсөгч
■ МБСБ төгсөгч



3.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГА

3.1. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоо

ОУХБ-ын тодорхойлолтоор Хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээний байгууллага гэж аливаа хүн хөдөлмөрийн зах зээлд орох, хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлтийг даван туулахад нь дэмжлэг үзүүлэх, эдийн засгийн шилжилт өөрчлөлтийн үр нөлөөг бууруулахад чиглэсэн Засгийн газрын хөдөлмөрийн зах зээлийн бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй төрийн байгууллага юм.


Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 27.1-д “Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоо нь хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтан /хөдөлмөрийн алба/, хөдөлмөрийн биржээс бүрдэнэ” гэж заасны дагуу хөдөлмөрийн салбарын удирдлага, зохион байгуулалтын бүтэц тодорхойлогдож ирсэн.

Нийгмийн зөвшилцөлийн гурван талаас бүрдсэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл (ХЭҮЗ) нь хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэлэлцэж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөрүүдийг баталдаг. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ) хариуцан зохион байгуулдаг. Зураг 9-д ХНХЯ-ны харъяа байгууллагуудыг харуулав. Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, сургалтын бодлого, түүний хэрэгжилтийн асуудлыг хариуцсан ХНХЯ-ны газар, мэргэжилтнүүдийг Зураг 10-т харуулав.

ХХҮЕГ нь улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс (ХХҮГ/Х)-ийг арга зүй, удирдамжаар хангах, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан, програм хангамжийг сайжруулах чиглэлээр ажилладаг. ХХҮЕГ-ын нийт үндсэн ажилтнуудын тоо 67 бөгөөд үүнээс 6 нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газрын ажилтнууд байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг 21 аймагт ХХҮГ, Нийслэлд Хөдөлмөр эрхлэлтийн газар (ХЭГ), 9 дүүрэгт ХХҮХ, сум, хороонд Хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн хариуцан хэрэгжүүлж байна. Аймаг, дүүргийн ХХҮГ/Х нь Хөдөлмөр эрхлэлтийн албатай. Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан нийт 194 мэргэжилтэн аймаг, дүүргийн түвшинд ажиллаж байна. (Хүснэгт 6)

Зураг 9. ХНХЯ-НЫ ХАРЪЯА БАЙГУУЛЛАГУУД





ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний
хөгжлийн ерөнхий газар

Сэргээн засалт, сургалт,
үйлдвэрлэлийн төв

Хөгжлийн бэрхшээлтэй
хүүхдийн сэргээн засах
хөгжлийн төв

Аймаг, дүүргийн
мэргэжил сургалт
үйлдвэрлэлийн төв/
ШУТИС (37 нэгж)

“Өнөр бүл” Хүүхдийн
асрамжийн газар
(136)


Мэргэжлийн
боловсрол, сургалтын
үнэлгээ, мэдээлэл
арга зүйн төв

Олон улсын хүүхдийн
“Найрамдал”
цогцолбор



Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ,
хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ,
төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч

Зураг 10. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БОДЛОГЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН ХНХЯ-НЫ НЭГЖ, МЭРГЭЖИЛТНҮҮД



Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн гишүүд

Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Хяналт - шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хөгжлийн хэлтсийн дарга

Бүлгүүдийн хөдөлмөрийн харилцаа, нийгмийн түншлэл хариуцсан ахлах шинжээч

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, хороо, зөвлөл хариуцсан ахлах шинжээч

Хөдөлмөрийн аюулгүй байдал, нөхцөл хариуцсан ахлах шинжээч

Мэргэшлийн хүрээ, техникийн боловсрол хариуцсан ахлах шинжээч

Нийгмийн түншлэл, сургалтын хэрэглэгдэхүүн хариуцсан ахлах мэргэжилтэн

Төрийн албаны ангилал, зэрэглэл, цалин хөлсний асуудал хариуцсан мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, сурталчилгаа хариуцсан

Сургалтын агуулга, стандарт хариуцсан мэргэжилтэн

Чанарын баталгаажилт хариуцсан ахлах мэргэжилтний үүргийг түр орлон

Суралцагчийн хөгжил, төгсөлт хариуцсан мэргэжилтэн

Багшийн хөгжил, салбарын хүний нөөц хариуцсан мэргэжилтэн

Статистик мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн

Хөдөлмөрийн зах зээл, инновац, элсэлт хариуцсан мэргэжилтэн

Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсролын хяналт - шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн

Хүснэгт 6. АЙМАГ, ДҮҮРГИЙН ХХҮГ/Х-ИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН АЛБАНЫ АЖИЛТНЫ ТОО (2020 ОН)

Албан тушаал	Аймаг	Дүүрэг
Хөдөлмөр эрхлэлтийн албаны дарга	21	9
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөл хариуцсан мэргэжилтэн	35	15
Ажил мэргэжлийн чиг баримжаа, ажил зуучлал хариуцсан мэргэжилтэн *	22	9
Хөдөлмөрийн харилцаа/хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн **	5	1
Хөдөлмөрийн зах зээл дэх, ажлын байрны шилжилт хөдөлгөөн хариуцсан мэргэжилтэн	22	9
Гадаад ажилчидтай холбоотой хөдөлмөрийн зах зээл/ажил мэргэжлийн зөвлөгөө хариуцсан мэргэжилтэн***	12	6
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан хариуцсан ахлах мэргэжилтэн	21	7
НИЙТ	138	56

Эх сурвалж: Байгууллагын хүний нөөцийн мэдээлэл, ХХҮЕГ, 2020

* Зарим албанд АМЧБ, зөвлөгөө өгөх болон ажил олгогчтой зуучлах үйл ажиллагааг тус тусын мэргэжилтэн хариуцдаг.

** Хөдөлмөрийн харилцаа/хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хариуцсан мэргэжилтэн ажилладаг боловч, орон тоо хязгаартай газарт тухайн мэргэжилтэн байдаггүй.

*** Гадаад ажиллах хүч хариуцсан мэргэжилтэн нь орон тоо хязгаарлагдмал газарт хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг давхар хариуцаж ажилладаг.

Хөдөлмөр, халамжийн салбарт нийт 1,700 орчим төрийн албан хаагч ажиллаж, давхардсан тоогоор 2.4 сая нийгмийн халамжийн үйлчилгээ авагч, ажил хайгч иргэдэд үйлчилдэг. Ялангуяа сум, хороонд ажиллаж байгаа нэг мэргэжилтэн нь нийгмийн халамж болон хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг давхар хариуцан ачаалалтай ажилладаг. Чингэлтэй дүүргийн ХХҮХ-ийн ажилтнуудтай хийсэн ярилцлагын үеэр сум, хорооны хөдөлмөр, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний ажлын цагийн 80% нь халамжийн ажилд зориулагддаг учраас хөдөлмөрийн асуудлаа хариуцах цаг боломж хомс байдаг талаар дурдаж байсан. Гэхдээ ажилтнуудын ачаалал нь тухайн сум, хорооны хүн амын тоо, амьжиргааны түвшин, зорилтот бүлгийн иргэдийн тооноос мөн хамаардаг.

2012-2016 онд аймаг, дүүргийн Хөдөлмөрийн хэлтсүүд 724 ажилтны орон тоотой, Халамж үйлчилгээний хэлтэст 1,427 хүн ажиллаж байсан бол 2016 онд Хөдөлмөрийн яам болон Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамыг нэгтгэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болгон зохион байгуулснаар салбарын нийт орон тоог 1,550-аар баталж, 601 орон тоог цомхотгож байжээ. Энэ бүтцийн өөрчлөлтөөр дийлэнхдээ хөдөлмөрийн салбарын мэргэжилтнүүд цомхотгогдсон. Цаашид хөдөлмөрийн салбарын мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулах, ур чадварыг дээшлүүлэх, сургалтад хамруулах, дутагдалтай орон тоог нэмэгдүүлэх зэрэг асуудалд анхаарах шаардлагатай юм.

3.2. Дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага

Зөвлөхүүд ажлын даалгаврыг гүйцэтгэж байх хугацаандаа Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн ХХҮХ-ийн Хөдөлмөр эрхлэлтийн албаны дарга, ажилтнуудтай уулзалтууд хийж, тэдний ажлын байрны нөхцөлтэй танилцсан юм.

Швейцарын хөгжлийн агентлагаас санхүүжүүлэн хэрэгжүүлсэн “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн хүрээнд аймаг, дүүргийн ХХҮХ-үүдэд ганцаарчилсан зөвлөгөө өгөх болон бүлгийн сургалтын гэсэн 2 өрөөг тохижуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан. Гэхдээ эдгээр өрөөний ашиглалт хангалтгүй, зарим дүүргийн хэлтсүүд өөр зориулалтаар ашиглаж байна.

Түүнчлэн Дэлхийн банкны (ДБ)-ны “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн хүрээнд аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн албаны үйлчилгээний танхим, сургалтын өрөө зэрэгт 2019-2021 онд урсгал засвар хийсэн байна.

Дүүргийн ХХҮХ-үүдэд өдөрт дунджаар 20-30 хүн ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолт авах зорилгоор ирдэг бол ажилд зуучлуулах, хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдахаар 2-10 хүн л ирдэг байна. ХЭДС-ийн санхүүжилт орж ирэн ХЭД хөтөлбөрүүд зарлагдах үед санхүүгийн дэмжлэг авахыг хүссэн иргэд олноор ирдэг учраас үйлчлүүлэгчийн тоо эрс нэмэгдэж (ихэвчлэн 4 ба 9 дүгээр сард), зарим өдөрт 100-150 хүнд үйлчилдэг. Дүүргийн ХХҮХ-ийн Хөдөлмөр эрхлэлтийн албаны ажилтнуудын ажлын цагийн ихэнхийг санхүүгийн дэмжлэг хүссэн иргэдийн хүсэлтийг хүлээн авах, сонгон шалгаруулалт хийх, иргэдэд ажилгүйдлийн тэтгэмж авах, тодорхойлолт гаргаж өгөх зэрэг үйл ажиллагаанд зарцуулж, ажилгүй иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилд зуучлах үйлчилгээнд бага цаг зарцуулж байна. Энэ асуудлаар үйлчилгээ авахаар ирэх иргэдийн тоо ч цөөн байна.

Нийслэлийн төвийн 6 дүүргийн ХХҮХ-ийн Хөдөлмөр эрхлэлтийн нэг албанд 2022 оны 2 дугаар сарын байдлаар 6-8 хүн буюу нийтдээ 44 хүн ажиллаж байна.

Хүснэгт 7. ДҮҮРГИЙН ХХҮХ-ИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН АЛБАНЫ АЖИЛТНЫ ТОО (2022.02)

Албан тушаал	БГД	БЗД	ЧД	ХУД	СХД	СБД
Хөдөлмөр эрхлэлтийн албаны дарга	1	1	1	1	1	1
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөл хариуцсан мэргэжилтэн	2	3	2	1	2	2
Ажил мэргэжлийн чиг баримжаа, ажил зуучлал хариуцсан мэргэжилтэн	2	3	1	2	3	2
Хөдөлмөрийн харилцаа/хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн	1	1	1	-	1	1
Хөдөлмөрийн зах зээл дэх, ажлын байрны шилжилт хөдөлгөөн хариуцсан мэргэжилтэн	-	-	1	1	-	-
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан хариуцсан ахлах мэргэжилтэн	1	1	1	1	1	1
НИЙТ	7	9	7	6	8	7

Эх сурвалж. Дүүргүүдийн ХХҮХ-ийн Хөдөлмөр эрхлэлтийн алба

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор ХЭД хөтөлбөрийн хүрээнд ажилгүй иргэний хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээг буюу “профайлинг” хийх үйлчилгээг баталсан. Профайлинг хийх гэдэг нь иргэнийг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөтөлбөрт хамруулахаас өмнө түүний нөхцөл байдал, ур чадварыг үнэлж, ажилд зуучлахад хэр бэрхшээлтэй эсэхийг үнэлэх аргачлал юм. ХНХЯ-наас 2022 онд 50.0 мянган ажилгүй хүнд профайлинг үнэлгээ хийхээр төлөвлөжээ. Энэ чиглэлээр төслийн С бүрэлдэхүүн хэсгийн бодлогын зөвлөхүүд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Үйлчлүүлэгчид профайлинг хийхэд ажлын байрны зай талбай багтаамж багатайгаас олон иргэнд зэрэг үйлчилж чадахгүй эрсдэлтэй ч одоо ашиглахгүй байгаа ганцаарчилсан ярилцлагын өрөө зэргийг ашиглах боломжтой юм.

Түүнчлэн ХХҮГ/Х-ийн компьютер тоног төхөөрөмжийн 50-иас дээш хувь нь ашиглалтын хугацаа хэтэрсэн, хүчин чадал багатайгаас зарим програм хангамжийг ачааллахад хүндрэлтэй байдаг талаар ажилтнууд мэдээлж байв. “Профайлинг” хийхдээ цаасан маягт хэлбэрээр бус цахимаар буюу вэбэд суурилан хийх нь цаг хугацаа хэмнэхээс гадна бичиг хэргийн зардлыг бууруулна.

Дүүргийн ХХҮХ-ийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх ажлын байрны зургийг доор харуулав.

Зураг 11. ХХҮХ-ийн ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН АЛБА (ХЭА)-НЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАНХИМ



БГД-ийн ХХҮХ-ийн ХЭА



ЧД-ийн ХХҮХ-ийн ХЭА



ХУД-ийн ХХҮХ-ийн ХЭА



СХД-ийн ХХҮХ-ийн АМТ

Зураг 12. ДҮҮРГИЙН ХХҮХ-ИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАНХИМ



БГД-ийн ХХҮХ-ийн Ганцаарчилсан зөвлөгөө өгөх өрөө



БЗД-ийн ХХҮХ-ийн ганцаарчилсан зөвлөгөө өгөх өрөө



ЧД-ийн ХХҮХ-ийн Ганцаарчилсан зөвлөгөө өгөх өрөө



СХД-ийн ХХҮХ-ийн Ганцаарчилсан зөвлөгөө өгөх өрөө



СБД-ийн ХХҮХ-ийн Ганцаарчилсан зөвлөгөө өгөх өрөө


ХХҮХ нь ХЭД хөтөлбөр, төслийн арга хэмжээнээс гадна ажилгүй болон бусад иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх, ажлын байрны чиг баримжаа олгох, ажилд зуучлах үйлчилгээг хязгаарлагдмал хүрээнд үзүүлж байна. Цаашид ХЭД нийтлэг үйлчилгээг сайжруулж, иргэнийг угтаж,

хүрч үйлчилдэг болоход тохирсон үйлчилгээний танхимтай байх шаардлагатай. Нийслэлийн төвийн 6 дүүрэг болох Чингэлтэй, Сүхбаатар, Баянгол, Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн ХХҮХ-үүдийн ажлын байрны нөхцөлийг харахад өрөөнүүдэд зохион байгуулалт хийх замаар хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх боломжтой гэж үзэж байна. Түүнчлэн ажилгүй иргэдийг ажилд зуучлан ажилтай болгохын тулд ХХҮХ нь ажил олгогчидтой нягт холбоотой ажиллах шаардлагатай байна. ХХҮХ-ийн Хөдөлмөр эрхлэлтийн алба (ХЭА)-ны Ажил зуучлал хариуцсан мэргэжилтэн голдуу гадаадаас ажиллах хүч оруулж ирж байгаа байгууллагууд болон худалдан авах үйл ажиллагааны гэрээ байгуулсан байгууллагуудтай харьцаж ажилладаг байна. Цаашид ажилтнуудын одоогийн ажлын байрны тодорхойлолтод анализ хийж, чиг үүргийг оновчтой тодорхойлох нь зүйтэй юм.

3.3. Хорооны Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

МУ-ын сум, хороо болгонд Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн ажилладаг. 2020 оны эцсийн байдлаар Улаанбаатар хотын 169 хороонд 172 хүн, 330 суманд 411 хүн хөдөлмөр эрхлэлт, халамжийн мэргэжилтнээр ажиллаж байна.⁶ Хорооны мэргэжилтэн хөдөлмөр, халамжийн асуудлыг давхар хариуцдаг учраас ажлын цагийнхаа ихэнхийг халамжийн ажилд зориулдаг байна. Хүн амын нягтшилаас шалтгаалан хороогоор үйлчлүүлэх иргэдийн тоо өдөрт 30-80 байдаг боловч иргэдийн дийлэнх нь халамжийн асуудлаар ханддаг байна. Хорооны мэргэжилтэн нь хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн LMIS системд шинэ ажлын байрны бүртгэл, ажил хайгчийн бүртгэл болон ажлын байрны захиалгын мэдээллийг оруулдаг ба бусад дүүргүүдийн ажлын байрны захиалгыг харах боломжтой. Түүнчлэн дүүргийнхээ ХХҮХ-т сар бүр сарын тоо мэдээ, дэлгэрэнгүй тайлан илгээдэг. Ажил олгогчоос шинэ ажлын байрны бүртгэлийг ХЗЗ-2 маягтаар, иргэдийг ажил хайгчаар бүртгэхдээ ХЗЗ-1 маягтаар тус тус бүртгэн LMIS системд оруулдаг. Хөдөлмөр эрхлэлт, халамжийн мэргэжилтний ажлын чиг үүргийг дараах зураг 13-д харуулав.

Зураг 13. ХОРООНЫ МЭРГЭЖИЛТНИЙ АЖЛЫН БАЙРНЫ ЧИГ ҮҮРЭГ



Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны Хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээний мэргэжилтэн Б.Болортуяатай ярилцлага хийх үед дараах мэдээллийг өгсөн болно.

⁶ ХХҮҮЕГ-ын Хүний нөөцийн мэргэжилтнээс авсан тоо мэдээлэл.

4.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ОУХБ-ын Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай 1964 оны 122 дугаар конвенцийг Монгол улс 1976 онд соёрхон баталсан. Энэ конвенц нь гишүүн орон бүр бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийг устгах, ажиллах хүчний хэрэгцээг хангах, амьдралын түвшинг дээшлүүлэх, эдийн засгийн хөгжил, түүний өсөлтийг урамшуулах зорилгоор үр ашигтай, бүрэн, чөлөөт хөдөлмөр эрхлэлтийн сонголтод дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн идэвхтэй бодлогыг гол зорилго болгосон.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай Монгол Улсын хуульд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг **1) хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, 2) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ** гэсэн 2 төрөлтэй байна гэж заасан байдаг.

4.1. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг дараах хэлбэрээр хэрэгжүүлдэг. Үүнд:

1. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;
2. Ажилд зуучлах;
3. Ажилгүйдлийн тэтгэмж авах иргэдийг бүртгэх;
4. Нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах;
5. Бусад үйлчилгээ.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг ХХҮЕГ, аймгийн ХХҮГ, Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, ХХҮХ болон эрх бүхий сургалтын байгууллага, биржээр дамжуулан хэрэгжүүлж байна.

АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ, ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ҮЙЛЧИЛГЭЭ

Оксфордын англи хэлний тольд “Career” гэдгийг “хувь хүний насан туршийн үйл хөдлөл буюу хөгжил дэвшил” (эсвэл амьдралын тухайн ялгаат хэсэг) гэж тодорхойлсон байдаг. Манай улсад хөдөлмөр эрхлэлтийн салбарт “Ажил мэргэжил” хэмээн орчуулж хэвшээд байна.

НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын хэрэглэдэг илүү дэлгэрэнгүй нэр томъёоны дагуу бол “карьер” гэдэг нь хувь хүний амьдралд хөлстэй ба хөлсгүй ажлыг аль алиныг нь оролцуулан ажил хийх үүрэг болон амь зуулгын бусад үүрэг насан туршид нь харилцан ээлжлэхийг хэлнэ.⁷ ЭЗХАХБ-ын тодорхойлсноор “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ гэж хувь хүний ажил амьдралын аль ч үед, нас харгалзахгүй сурч боловсрох, мэргэжил дээшлүүлэх, ажил мэргэжлийн сонголт, менежмент хийхэд нь туслалцаа үзүүлэх үйлчилгээ, түүнд чиглэсэн үйл ажиллагаа”⁸-г хэлдэг.

Зах зээлийн орнуудад ажил мэргэжлийн чиг баримжаа, зөвлөгөө нь дараах таван үндсэн чиглэлд хуваагддаг⁹. Үүнд:

- 1. Ажил мэргэжлийн талаарх мэдээлэл (Career information).** Энэ нь цалинтай эсвэл сайн дурын аливаа хөдөлмөр эрхлэлтийг төлөвлөх, ажилд орох ба ажлын байраа хадгалахад шаардагдах бүх мэдээллийг хамруулна. Үүнд: мэргэжил, ур чадвар, албан тушаал ахих, сурч боловсрох боломж, хөдөлмөрийн зах зээлийн цаашдын чиг хандлага ба нөхцөл, боловсролын хөтөлбөр ба боломж, боловсрол ба сургалтын талаарх төрийн болон төрийн бус хөтөлбөр, үйлчилгээ, ажлын байр, бусад асуудлын талаарх мэдээлэл тусгагдана.
- 2. Ажил мэргэжлийн боловсрол (Career education).** Үүнийг боловсролын байгууллагууд олгох бөгөөд зарим тохиолдолд ажил мэргэжлийн зөвлөх, ажил дээр дадлагажуулагч багш, хамт олноос тодорсон бусад хүмүүс ч зааж сургана. Энэ нь оюутнуудад өөрсдийнхөө үнэ цэнийг ойлгож нийгэмд хувь нэмрээ оруулах, тэднийг хөдөлмөрийн зах зээлийн тухай мэдлэгтэй, боловсрол, сургалт, амьдрал болон ажил мэргэжлийн талаар зөв сонголт хийх чадвартай болгож, нөгөө талаар хамт олонд үзүүлэх үйлчилгээ, өдөр тутмын амьдралаа зохицуулах, ажил мэргэжлээ төлөвлөх арга барилыг эзэмшүүлнэ.
- 3. Ажил мэргэжлийн зөвлөгөө (Career counselling).** Энэ нь хүмүүст өөрсдийнхөө зорилго, хүсэл эрмэлзлийг илүү тодорхой болгох, өөрийнхөө төлөв байдлыг ойлгох, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах, үйл ажиллагаандаа хариуцлагатай хандах, төлөвлөсөн болон төлөвлөөгүй ажил мэргэжлийн өөрчлөлтийг даван туулах, удирдах зэрэгт туслалцаа үзүүлнэ.
- 4. Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөгөө (Employment counselling).** Энэ нь хүмүүст хөдөлмөр эрхлэлтийн ойрын зорилтыг тодорхойлох, тухайн ажлын байранд шаардагдах ур чадварын талаарх ойлголт, суралцах боломжийг нээх мөн ажил хайх, ажлын байрандаа тогтвортой ажиллахад шаардагдах ур чадварт суралцахад туслалцаа үзүүлнэ. Тухайлбал, товч намтар /CV/ бичих, анкет бөглөх, ажлын ярилцлаганд орох ур чадвар гэх мэт болно.
- 5. Ажлаар хангах (Job placement).** Хүмүүсийг ажлаар хангах, сул чөлөөтэй ажлын байрыг санал болгох үйлчилгээ юм.

АЖИЛД ЗУУЧЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.10 дах заалтад “ажилд зуучлах” гэж ажил хайж байгаа иргэнд хүсэл сонирхол, мэргэжил, ур чадварт нь тохирсон ажил олоход, ажил олгогчид эрэлт хэрэгцээнд нь нийцсэн ажилтан олоход туслалцаа үзүүлэх үйлчилгээг хэлнэ гэж тодорхойлсон байна.

Олон улсад “ажилд зуучлах” гэдэг нь ажил хайгч болон ажил олгогчийн хооронд хөдөлмөрийн харилцаа үүсгэхийн тулд тэднийг холбож нэгтгэхэд чиглэсэн үйл ажиллагаа юм. (Ulrich Walwei 1996).

⁷ United Nations Educational, Scientific and Cultural Organization. Handbook on career counselling a practical manual for developing, implementing and assessing career counselling services in higher education settings, Paris, 2002

⁸ OECD ба Европын Комисс: Ажил мэргэжлийн чиг баримжаа: Бодлого боловсруулагчдад зориулсан гарын авлага. (OECD/Европын Комисс, Парис, 2004), хуудас 10

⁹ “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх төв байгуулахад баримтлах зөвлөмж” гарын авлага, Д.Нармандах, Вульф Шмайдер. 2016

Ажилд зуучлах нь эрх бүхий оролцогч талуудын хооронд хөдөлмөрийн харилцааг үүсгэхэд чиглэсэн үйл ажиллагаануудыг хамардаг. (M Ruebner und Jaeger, 2014)

Хүснэгт 8. АЖИЛД ЗУУЧЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮСЭЛ¹⁰

Төрийн ажилд зуучлах үйлчилгээ	Үүссэн он	Хувийн ажилд зуучлах үйлчилгээ	Үүссэн он
ШВЕД	1902	ИХ БРИТАН / GABBITAS & THRING", JOHN GABBITAS/	1873
ИХ БРИТАН /1650 ОНД АНГЛИЙН СУДЛААЧ HENRY ROBINSON САНААЧИЛСАН/	1905	АНУ /FRED WINSLOW ИНЖЕНЕР/	1893
НОРВЕГИ	1906	ШВЕЙЦАР	1910
ЯПОН	1909	АВСТРИ	1918
АВСТРИ	1918	АВТСРАЛИ	1947
GERMAN	1927	ИРЛАНД	1970
АНУ /ВАГНЕР ПЕЙЗЕРИЙН АКТ/. 1998 ОНООС НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ХЭРЭГЖДЭГ/	1933	ИЗРАЙЛ	1989
ШИНЭ ЗЕЛАНД, БЕЛГИ	1935	НОРВЕГИ	1993
НИДЕРДАНД	1940	ДАНИ	1994
ИСПАНИ	1943	GERMAN	1994
ФРАНЦ, КИПР	1945		
ТУРК, АВТСРАЛИ	1946		
ИСЛАНД	1956		
ИЗРАЙЛ	1959		
ПОРТУГАЛ	1966		
БОЛГАРИ	1989		

Олон улсын туршлагаас харахад төрийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хувийн хөдөлмөр зуучлалын байгууллага нягт уялдаатай ажилладаг. Жишээ нь, Япон Улсад ажилд зуучлагдан орсон хүний цалингийн 10, түүнээс дээш хувийг тухайн ажил олгогч нь хөдөлмөрийн биржүүдэд жилийн хугацаанд олгодог жишиг байдаг. Хөдөлмөр зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих асуудлыг төрийн бус байгууллага хариуцдаг тогтолцоотой байна. Харин БНСУ-д хөдөлмөрийн биржүүдэд улсаас болон орон нутгийн төсвөөс санхүүжилт олгодог, тухайн дүүргийн бүтээн байгуулалттай холбоотой түр зуучлалын төв ажиллуулдаг, төрөлжсөн хөдөлмөрийн бирж, цагийн ажилд зуучлах төвүүд гэх мэт олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

Монгол Улсад ажилд зуучлах чиг үүргийг аймаг, дүүргийн ХХҮХ, хувийн хөдөлмөрийн биржүүд гүйцэтгэж байна. 2021 оны байдлаар ХХҮЕГ-т 88 хөдөлмөрийн хувийн бирж бүртгүүлсэн бөгөөд 32 хөдөлмөрийн бирж нь үйл ажиллагаа явуулж ХЭДС-аас санхүүжилтээ авч байна.

Хувийн хөдөлмөрийн биржүүд нь Стандартчилалын үндэсний зөвлөлөөс баталсан Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавих шаардлага MNS6620:2016 стандартыг баримтлан ажилладаг. Монгол Улс 2016 онд соёрхон баталсан "Хөдөлмөр эрхлэлтийн хувийн албадын тухай" ОУХБ-ын 181-р конвенц, конвенцийн 188-р зөвлөмж; "Хөдөлмөр эрхлэлтийн албаны тухай" ОУХБ-ын 88 дугаар конвенц,

¹⁰ "Ажил мэргэжлийн чиг баримжаа" Судлаачид (Г. Түмэннаст, М.Шарпф, Йо. Эртельт, 2018. Х.14)

конвенцийн 83 дугаар зөвлөмжийн дагуу хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үнэ төлбөргүй зохион байгуулах, хүүхдийн хөдөлмөр ашиглахгүй байх гэсэн зарчмыг мөрдөн ажиллаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг ХХҮЕГ, НХЭГ, аймгийн ХХҮГ, дүүргийн ХХҮХ, эрх бүхий хувийн биржүүд, эрх бүхий сургалтын байгууллагууд хэрэгжүүлж байна. Чиг үүргээ гэрээгээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд ХХҮЕГ-аас гаргасан удирдамжийн дагуу 1 иргэнээр тооцож урьдчилгаа 70 хувь, сургалтын тайлан өгснөөр үлдэгдэл 30 хувийн санхүүжилтийг олгодог.

ХХҮЕГ нь жил бүр сонгон шалгаруулалт зарлаж шаардлага хангасан байгууллагад хувийн хөдөлмөрийн биржийн үйл ажиллагаа явуулах 2 жилийн зөвшөөрөл олгодог бөгөөд жил бүр гэрээний гүйцэтгэлийг дүгнэдэг. Хувийн биржийн хувьд сар бүрийн 26-наас өмнө цахим мэдээллийн санд ажилд зуучилсан иргэдээ бүртгэж, гүйцэтгэлийн тайлангаа цаасан хэлбэрээр ХХҮЕГ-т өгдөг. ХХҮЕГ-ын ажил мэргэжлийн чиг баримжаа, хөдөлмөрийн биржүүдийн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн хянаж шалгаснаар дараа сард нь санхүүжилтийг олгодог байна. ХЭДС-ийн санхүүжилт 3 дугаар сараас эхэлж олгогддог учраас 1 ба 2 дугаар сарын тайланг 3 дугаар сард хүлээж авдаг байна.

Хүснэгт 9. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	Зохион байгуулах байгууллага	Хэрэгжүүлэгч буюу санхүүжилт авах байгууллага	Санхүүжилтийн арга
1 Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	НХЭГ, Аймаг дүүргийн ХХҮХ	Эрх бүхий сургалтын байгууллага	1 иргэнээр, урьдчилгаа 70%, сургалт дуусч тайлан өгснөөр гүйцэтгэл 30%
2 Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	ХХҮЕГ	Хөдөлмөрийн хувийн бирж	Гүйцэтгэлийн тайлангаар 100%
3 Ажилд зуучлах үйлчилгээ	НХЭГ, Аймаг дүүргийн ХХҮХ	НХЭГ, Аймаг дүүргийн ХХҮХ	Төсвийн гүйцэтгэлээр
4 Ажилд зуучлах үйлчилгээ	ХХҮЕГ	Хөдөлмөрийн хувийн бирж	Гүйцэтгэлийн тайлангаар 100%

Зарим аймаг, дүүргийн ХХҮХ нь ганцаарчилсан зөвлөгөө өгөх өрөө байхгүй эсхүл үйлчлүүлэх хүний тоо харьцангуй их байдаг учраас нийтлэг үйлчилгээг шаардлагын дагуу хүргэх боломжгүй байдаг. Тиймээс ажил мэргэжлийн чиг баримжаа (АМЧБ) олгох зөвлөх үйлчилгээг гэрээлэн гүйцэтгүүлдэг байна. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэхэд Аймаг, дүүргийн ХХҮХ болон хөдөлмөрийн хувийн биржийг өөр өөр зардлын тарифаар санхүүжүүлдэг. (Хүснэгт 9)

Хүснэгт 10. НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙН ТАРИФ

Нийтлэг үйлчилгээ		Тариф (Төг)	Эрх зүйн үндэслэл
Аймгийн ХХҮГ, дүүргийн ХХҮХ			
1	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээ	Ганцаарчилсан	12,000
		Бүлгээр	6,000
2	Ажилд зуучлах үйлчилгээ	7,000	ХНХ-ын Сайдын 2021 оны 6 сарын 18-ны А/96 тушаал “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний зардлын жишиг хэмжээ”
Хөдөлмөрийн хувийн бирж			
1	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээ	Ганцаарчилсан	12,500
		Бүлгээр	126,000
2	Ажилд зуучлах үйлчилгээ	Энгийн	12,500
		Бүтээмж өндөр салбарт ажилд оруулах	17,500
		МСҮТ, ИДС төгсөгчийг тухайн жилд нь багтааж ажилд оруулах	25,000
		Ажилд зуучлан оруулсан ажилтны тогтвортой ажилласан 3, 6, 12 дахь саруудад олгох урамшуулал	Ажил хайгч, ажилгүй иргэн
		40-өөс дээш насны ажилгүй иргэн	126,000-525,000
		Ажил олоход хүндрэлтэй иргэн	147,000-630,000
			Хөдөлмөрийн сайдын 2014 оны 5 сарын 27-ны А/123 Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж санхүүжилт /тарифаар тооцож/ олгох журам

НХЭГ, Аймаг, дүүргийн ХХҮХ-үүд нь иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх төлөвлөгөөнийхөө 20-30 хувийг өөрсдөө, 70-80 хувийг эрх бүхий сургалтын байгууллагуудтай гэрээ байгуулан гүйцэтгүүлдэг байна.

Хөдөлмөрийн хувийн биржүүдийн хувьд үйл ажиллагааны урсгал зардлаа (түрээс, харилцаа холбоо, интернет, ажилтны цалин, зар сурталчилгаа г.м) өөрсдөө хариуцдаг учраас нэг хүнд ногдох зуучлалын өртөг өндөр байдаг. Тиймээс зуучлалын тарифыг өсгөх хүсэл сонирхолоо байнга илэрхийлдэг ажээ. Хэдийгээр ажилд зуучлах үйлчилгээний тариф зорилтот үйлчлүүлэгчээсээ шалтгаалаад гурван өөр тарифтай боловч ихэвчлэн энгийн тарифаар тооцож санхүүжилт олгодог. Хувийн биржээр үйлчлүүлсэн иргэд нь ажил олгогчийн шаардсан ур чадварыг эзэмших, мэргэжлийн болон давтан сургалт болон бусад чадавхжуулах сургалтад хамрагдах хүсэлтэй байдаг ч хувийн биржүүдэд ийм төсөв олгодоггүй учир төлбөртэй сургалтыг санал болгох эсвэл харъяа дүүргийн ХХҮХ-т хандахыг зөвлөдөг байна. Харин НХЭГ, Аймгийн ХХҮГ, дүүргийн ХХҮХ нь тарифт зардлаа өдөрлөг яармаг зохион байгуулах, харилцаа холбоо, зар сурталчилгаа, брошур хэвлүүлэх гэх мэт зуучлалтай холбоотой үйл ажиллагааны зардалд зарцуулдаг байна.

4.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, хэрэгжилт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн Гуравдугаар бүлэгт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг дараах төсөл, хөтөлбөрийн хэлбэрээр хэрэгжүүлнэ гэж заасан. Үүнд:

1. Хөдөлмөрт бэлтгэх;
2. Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах;
3. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг дэмжих, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих;
4. Ажил олгогчийг дэмжих;
5. Нийтийг хамарсан ажил зохион байгуулах;
6. Ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;
7. Хууль тогтоомжид болон Засгийн газар, ХЭҮЗ-ийн шийдвэрээр тодорхойлсон бусад төсөл, хөтөлбөр.

ХЭҮЗ-ийн 2021 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дараах 5 хөтөлбөр, арга хэмжээг баталсан. Үүнд:

1. Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр
2. Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр
3. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
5. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 5 хөтөлбөрийн нийт 18 арга хэмжээ нь 24 бүлгийн зорилтот хэсэгт чиглэсэн байна. (Хүснэгт 10) Хөтөлбөрт тусгагдсан 18 арга хэмжээг хэрэгжүүлж буй хэлбэр, санхүүжилтийн задаргаагаар нь ангилбал 34 арга хэмжээ болж байгаагаас 8 арга хэмжээг ХБХХЕГ хариуцан хэрэгжүүлж 24-26 арга хэмжээг ХХҮЕГ, НХЭГ, аймаг дүүргийн ХХҮГ, хэлтэс хэрэгжүүлж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2021 оны хөтөлбөр нь нийгмийн халамжаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэл рүү шилжиж буйгаараа, мөн коронавируст халдварын эсрэг авч буй арга хэмжээгээрээ онцлогтой. “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд нийгмийн халамжийн үйлчилгээ авч байгаа, хөдөлмөр эрхлэх боломжтой залуусын хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. «Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр» нь коронавируст халдвараас болж бизнес нь хүнд байдалд орсон бизнес эрхлэгчдэд бизнесээ хөгжүүлэхэд нь, малчдад малаа өсгөхөд нь нэмэр болгох зорилгоор хүүгүй зээл олгоно.

Хүснэгт 11. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР (2021-2022)

Хөтөлбөр	Хөтөлбөрийн арга хэмжээ	Хамрах хүрээ
ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ ХӨТӨЛБӨР	<ol style="list-style-type: none"> 1. Хөдөлмөрт бэлтгэх 2. Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах 3. Нийгмийн хариуцлагатай ажил олгогчийг шалгаруулах 	<ul style="list-style-type: none"> • Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай гишүүн; • Сургууль завсардсан хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхэд; • Хорих ангиас суллагдсан иргэн; • Асрамжийн газраас гарсан иргэн; • 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэн
ЦАР ТАХЛЫН ҮЕД АЖ АХУЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ СЭРГЭЭХ ХӨТӨЛБӨР	<ol style="list-style-type: none"> 4. Иргэн, ААН-д санхүүгийн дэмжлэг олгох 5. Малчдын малжуулах 6. Борлуулалтын дэмжлэг үзүүлэх 7. Ажил олгогчийг дэмжих 8. Нийтийг хамарсан ажил зохион байгуулах 	<ul style="list-style-type: none"> • Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч; • Нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч; • Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн; • Гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэн; • Малгүй болон цөөн малтай өрхийн гишүүн; • Гэрээт малчин өрхийн гишүүн; • Ажилгүй иргэн
ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР	<ol style="list-style-type: none"> 9. Залуучуудад хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх 10. Залуучуудад ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх 11. Шилдэг "Старт-Ап" залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох 12. Оюутан залуучуудыг цагийн ажилд зуучлах 	<ul style="list-style-type: none"> • 15-34 насны ажилгүй, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа залуучууд; • Их, дээд сургууль, МБСБ төгсөөд 3 хүртэл жил болж байгаа, эзэмшсэн мэргэжлээрээ ажилласан туршлагагүй ажил хайж буй залуучууд; • Их, дээд сургууль болон МБСБ; • Аж ахуйн нэгж, байгууллагууд
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР	<ol style="list-style-type: none"> 13. ХБИ-г хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх 14. Санхүүгийн дэмжлэг олгох 15. ХБИ-д ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх 	<ul style="list-style-type: none"> • ЭХМК-ийн шийдвэртэй, хөдөлмөрийн чадвараа алдсан ХБИ; • Байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг эх; • ХБИ-ийг ажлын байраар хангаж буй ажил олгогч; • ХБИ-ний эрх ашгийг хамгаалах чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулдаг, ХБИ-ийг ажлын байраар хангаж байгаа ТББ; • ХБИ-ийг ажлын байраар хангаж байгаа ажил олгогч.
АХМАД НАСТНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР	<ol style="list-style-type: none"> 16. Ахмад настны зөвлөх үйлчилгээг зохион байгуулах 17. Ахмадын ТББ-уудаар зөвлөх үйлчилгээг зохион байгуулах 18. Эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгох 	<ul style="list-style-type: none"> • ХХҮГ, хэлтэст хүсэлт гарган мэдээллийн санд бүртгүүлсэн тэтгэврийн насны ахмад мэргэжилтнүүд; • Ахмад настны эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ, холбоод; • Аж ахуй, өрхийн үйлдвэрлэл эрхлэх зорилготой ахмад настан.

ХЭД хөтөлбөрийн хамрах хүрээг харахад хөдөлмөрийн зах зээлд шууд нэвтрэхэд бэрхшээлтэй, удаан хугацааны сургалт, зөвлөгөө арга хэмжээ шаардлагатай иргэдэд голдуу чиглэсэн байна. Харин бүтцийн

ажилгүйдэл, түр ажилгүйдэлд өртсөн, хөдөлмөр эрхлэлтийн дэмжлэг, нэмэлт үйлчилгээ авснаар хөдөлмөрийн зах зээлд оролцоход бэлэн ажил хайгчид чиглэсэн хөтөлбөр арга хэмжээ дутмаг байна.

ХЭДС-ийн 2021 оны 10 дугаар сарын зарцуулалтын тайлангаас харахад Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр 29.1 хувь, Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр 60.1 хувь, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 50.4 хувь, ХБИ-ний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 38.5 хувь, Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 77.8 хувь тус тус гүйцэтгэлтэй байна. ХХҮЕГ-аас ХЭД хөтөлбөрийн төлөвлөгөөний 70 хувийг эхний хагас жилд гүйцэтгэхийг удирдамж болгодог боловч энэ нь бодит байдалд хэрэгжихгүй байна. (Хүснэгт 12)

Хүснэгт 12. ХЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө		Гүйцэтгэл 2021 оны 10 дугаар сард		Гүйцэтгэлийн биелэлт, хувиар	
	хүнээр	төгрөгөөр	хүнээр	төгрөгөөр	хүнээр	төгрөгөөр
1. Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр	7,520	595,727,170	2,545	173,538,800	33.8%	29.1%
2. Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр	18,213	12,296,848,200	9,507	7,391,179,345	52.2%	60.1%
3. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	11,602	810,200,000	1,855	408,261,680	16.0%	50.4%
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	3,295	8,544,105,300	1,589	3,290,294,100	48.2%	38.5%
5. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	759	1,224,051,000	521	952,841,500	68.6%	77.8%
НИЙТ	41,389	23,724,947,670	16,017	12,301,330,425	38.7%	51.8%

Эх сурвалж. ХХҮЕГ-аас гаргасан ХЭДС-ийн мэдээ, 2021 оны 11 сар


ХЭДС-ийн орлогын эх үүсвэр гадаадын иргэн ажиллуулдаг ААН-үүдийн төлөх ажлын байрны төлбөр, улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө, өмнөх оны эцсийн үлдэгдлээс голчлон бүрддэг. Уул уурхай, барилгын салбарын ААН-үүд гадаад иргэнийг (ихэвчлэн БНХАУ-ын) улирлын чанартайгаар авч ажиллуулдаг гол салбарууд юм. Жил бүрийн 3 дугаар сараас гадаад ажилтны ажлын байрны төлбөр орж ирдэг тул ХЭДС-ийн орлого жилийн эхний саруудад бага байдаг. ХЭДС-ийн орлогын эх үүсвэрээс шалтгаалан ХЭД хөтөлбөрийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх бодит хугацаа 4-6 дугаар сар, 9-12 дугаар сар хүртэлх хугацаанд идэвхиждэг байна.

4.3. ХЭД үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага, оролцогчид

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны оролцогчид нь бодлого боловсруулагч ЗГ, ХНХЯ, бусад яамд, бодлогын хэрэгжилтийг зохион байгуулагч ХХҮЕГ болон НХЭГ, аймгийн ХХҮГ, дүүргийн ХХҮХ, бодлого, хэрэгжилтийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэгч ОУ-ын төсөл хөтөлбөр, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл арга зүйн төв, ХНХСИ, мэргэжлийн холбоод, үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэгч хөдөлмөрийн биржүүд, сургалтын байгууллага, ажил олгогч, ТББ, ашиг хүртэгч буюу хөтөлбөрт хамрагдах иргэд, бизнес эрхлэгч, ажилгүй иргэд юм.

Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд оролцогч талуудын мэдээлэлд үндэслэж 2021 онд хэрэгжиж буй хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд SWOT шинжилгээ хийлээ.

Зураг 14. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ SWOT ШИНЖИЛГЭЭ



Нөхцөл байдлын дүн шинжилгээнээс үзэхэд хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаа нь боломж давуу тал ихтэй, олон сонирхогч талуудтай, санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжтой, үйл ажиллагааны хамрах хүрээгээ өргөжүүлэх, орчин үеийн хувьсан өөрчлөгдөж буй хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулан тогтолцоогоо шинэчлэх боломжтой байна.

ХЭД ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

2021 онд хэрэгжүүлсэн ХЭД 5 хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ХХҮЕГ удирдлага арга зүйгээр улсын хэмжээнд хангаж, НХЭГ, 21 аймгийн ХХҮГ, 9 дүүргийн ХХҮХ хэрэгжилтийг зохион байгуулсан байна.

ХЭҮЗ-өөс ХЭД хөтөлбөрийг баталж, хөтөлбөр, нийтлэг үйлчилгээг тухайн онд зохион байгуулах нэгдсэн удирдамжийг ХНХ-ын Сайдын тушаалаар баталсны дараа ХХҮЕГ, аймаг, дүүргийн ХХҮГ/Х нь арга хэмжээнүүдээ нийтэд зарлаж, зохион байгуулалтыг эхлүүлдэг. ХХҮЕГ нь 3 нийтлэг үйлчилгээ, ХЭД 3 хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулдаг. ХЭД хөтөлбөрүүдийн арга хэмжээнүүдээс НХЭГ нь 7, аймгийн ХХҮГ нь 22, Дүүргийн ХХҮХ нь 13, алслагдсан дүүргүүд буюу Багахангай, Багануур, Налайх дүүргийн ХХҮХ нь 21 арга хэмжээний хэрэгжилтийг тус тус зохион байгуулдаг байна. (Хүснэгт 12-16)

Хүүхэд хамгааллын төсөл, Дэлхийн банкнаас эх үүсвэрийг олгож байгаа жижиг зээлийн арга хэмжээг аймаг, дүүргийн ХХҮГ/Х арилжааны банкуудаар дамжуулан зохион байгуулж байна. ХЭД хөтөлбөрийн зарим арга хэмжээг тухайлбал, хөдөлмөрт бэлтгэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлийн болон давтан сургалт, үйлдвэр дээрх сургалт, старт ап-ийг шалгаруулах зэрэг арга хэмжээг эрх бүхий сургалтын болон мэргэжлийн байгууллагуудаар гэрээлэн гүйцэтгүүлдэг.

Хүснэгт 12-16-д ХЭД хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллагууд, хөтөлбөрийн арга хэмжээний санхүүжилтийн аргыг хөтөлбөрийн арга хэмжээ тус бүрээр дэлгэрэнгүй гаргав. ХЭД хөтөлбөрийн арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо тарифаар, боломжит санхүүжилтийн дээд хязгаарыг тогтоох замаар, гүйцэтгэгч байгууллагын үнийн саналыг харгалзан үзэх гэсэн 3 үндсэн аргыг ашиглаж байна.

Хүснэгт 13. ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

Хөтөлбөрийн арга хэмжээ		Хэрэгжүүлэгч, санхүүжилт олгох байгууллага	Гүйцэтгэгч байгууллага	Санхүүжүүлэх арга	
1.1.	Хөдөлмөрт бэлтгэх	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө, мэдээлэл өгөх	Аймаг, дүүргийн ХХҮХ	Хувийн бирж, мэргэжлийн холбогдох байгууллага	1 иргэнээр тооцож, урьдчилгаа 70% олгоно, сургалт дуусч тайлан өгснөөр гүйцэтгэл 30%
		Ажлын байрны харилцаа, сэтгэл зүйн сургалт зохион байгуулах	Аймаг, дүүргийн ХХҮХ	Сургалтын байгууллага	
		Ажилд зуучлах уулзалтад бэлтгэх	Аймаг, дүүргийн ХХҮХ	Аймаг, дүүргийн ХХҮХ	
1.2.	Мэргэжлийн болон давтан сургалт зохион байгуулах	Танхимын сургалт зохион байгуулах	НХЭГ, Аймаг, алслагдсан 3 дүүргийн ХХҮХ	Эрх бүхий мэргэжлийн сургалтын байгууллага	1 иргэнээр тооцож, урьдчилгаа 70% олгоно, сургалт дуусч тайлан өгснөөр гүйцэтгэл 30%
		Үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулах	НХЭГ, Аймаг, алслагдсан 3 дүүргийн ХХҮХ	Ажил олгогч	
1.3.	Нийгмийн хариуцлагатай ажил олгогчийг шалгаруулах	ХХҮЕГ	Холбогдох журам батлагдаагүйн улмаас зохион байгуулаагүй		

Хүснэгт 14. ЦАР ТАХЛЫН ҮЕД АЖ АХУЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ СЭРГЭЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

Хөтөлбөрийн арга хэмжээ		Зохион байгуулах, санхүүжилт олгох байгууллага	Гүйцэтгэгч байгууллага	Санхүүжилтийн арга	
2.1	Иргэн, аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг олгох	Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох/ эргэн төлөлттэй/	Аймаг, дүүргийн ХХҮХ	Хамрах хүрээнд заасан иргэн, аж ахуйн нэгж	Сонгон шалгаруулалтаар 100%
		Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах	Аймаг, дүүргийн ХХҮХ	Эрх бүхий сургалтын байгууллага	1 иргэнээр, урьдчилгаа 70%, сургалт дуусч тайлан өгснөөр гүйцэтгэл 30%
		Богино хугацааны эргэлтийн хөрөнгийн дэмжлэг олгох / fintech/	Аймаг, дүүргийн ХХҮХ	Зохицуулах журам гараагүй учраас хэрэгжээгүй	Сонгон шалгаруулалтаар 100%
		Ажил олгогчид олгох дэмжлэг	Аймаг, дүүргийн ХХҮХ	Хөтөлбөрт заасан ажил хайгчийг ажилд авч гэрээ байгуулсан ажил олгогч	Гүйцэтгэлийн тайлангаар 100%
2.2	Малчдыг малжуулах	Малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох	НХЭГ, Аймаг, алслагдсан 3 дүүргийн ХХҮХ	НХЭГ, Аймаг, алслагдсан 3 дүүргийн ХХҮХ	Гүйцэтгэлээр 100%
		Гэрээт малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох	НХЭГ, Аймаг, алслагдсан 3 дүүргийн ХХҮХ газар, хэлтэс	НХЭГ, Аймаг, алслагдсан 3 дүүргийн ХХҮХ	Гүйцэтгэлээр 100%
		Үйл ажиллагааны зардал	НХЭГ, Аймаг, алслагдсан 3 дүүргийн ХХҮХ	НХЭГ, Аймаг, алслагдсан 3 дүүргийн ХХҮХ	Гүйцэтгэлээр 100%
		Мал маллах арга ухааны сургалт, уулзалт зохион байгуулах	НХЭГ, Аймаг, алслагдсан 3 дүүргийн ХХҮХ	Туршлагатай сайн малчин	Гүйцэтгэлээр 100%
2.3	Борлуулалтын дэмжлэг үзүүлэх арга хэмжээ	Аймаг, дүүргийн хөдөлмөр ХХҮХ	Өдөрлөг, яармаг зохион байгуулсан байгууллага	Урьдчилгаа 70%, тайлан өгснөөр гүйцэтгэл 30%	
2.4	Нийтийг хамарсан ажил зохион байгуулах	НХЭГ, Аймаг, дүүргийн ХХҮХ	Орон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, ТББ зохион байгуулж, түр ажлын байраар хангагдсан иргэнд цалин олгоно	Тайлангийн дараа хувь иргэнд 100% олгоно	

Хүснэгт 15. ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

Хөтөлбөрийн арга хэмжээ		Зохион байгуулах, санхүүжилт олгох байгууллага	Гүйцэтгэгч байгууллага	Санхүүжилтийн арга	
3.1	Залуучуудад ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх	Нийгмийн түншлэлийн байгууллагуудтай хамтран залуучуудыг ажлын байранд зааж сургах, дараа үеийн боловсон хүчнийг бэлтгэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд чиглүүлэх менторшип хөтөлбөрт хамруулах	Сонгогдсон аймаг, дүүргийн ХХҮХ, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл /БГД	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв	ШХА-ийн “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслөөс санхүүжүүлж ирсэн
3.2	Шилдэг “Старт-Ап” залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох	Шилдэг “Старт-Ап” залуу, залуучуудын багийг сонгон шалгаруулах	НХЭГ, Аймгийн ХХҮГ	Эрх бүхий байгууллагын шалгаруулсан Старт-ап	Ялагч багт 100% олгоно
		“Старт-Ап” залуучуудад ментор хийх	НХЭГ, Аймгийн ХХҮГ	Эрх бүхий байгууллага	Урьдчилгаа 70%, тайлан өгснөөр гүйцэтгэл 30%
		Улсын хэмжээнд “Старт-Ап” залуу, залуучуудын багийг сонгон шалгаруулах	НХЭГ, Аймгийн ХХҮГ	Эрх бүхий байгууллагын шалгаруулсан Старт-ап	Ялагч багт 100% олгоно
3.3	Оюутан залуучуудыг цагийн ажилд зуучлах*	ЗГ-ын 2020 оны 228 дугаар тогтоолоор батлагдсан Оюутны цагаар хөдөлмөр эрхлэх журмын хэрэгжилтийг хангах, цагийн ажилд зуучлах	НХЭГ, Аймгийн ХХҮГ	НХЭГ	Төлөвлөгөөний дагуу

* Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн оюутныг цагийн ажилд зуучлах арга хэмжээ орон нутагт төсөвлөгддөг боловч зарим орон нутагт их дээд сургууль байхгүй, цагаар ажиллах нөхцөл багатай, эрэлт байхгүйгээс энэ арга хэмжээ хэрэгждэггүй байна.

Хүснэгт 16. ХБИ-ИЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

Хөтөлбөрийн арга хэмжээ		Зохион байгуулах, санхүүжилт олгох байгууллага	Гүйцэтгэгч байгууллага	Санхүүжилтийн арга	
4.1	ХБИ-ийг хөдөлмөрийн нээлттэй зах зээлд ажиллахад нь дэмжлэг үзүүлэх	ХБХХЕГ	Сонгон шалгаруултад тэнцсэн байгууллага	Урьдчилгаа 70%, тайлан өгснөөр гүйцэтгэл 30%	
4.2	Санхүүгийн дэмжлэг	Хувиараа хөдөлмөр эрхлэгчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх /50 хувь эргэн төлөлттэй/	Аймаг, дүүргийн ХХҮХ	Хувиараа хөдөлмөр эрхлэгч ХБИ	Сонгон шалгаруулалтаар 100%
		Төрийн бус байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлэх /эргэн төлөлтгүй/	ХБХХЕГ	Төсөл нь шалгарсан ТББ	Урьдчилгаа 70%, тайлан өгснөөр гүйцэтгэл 30%
		Аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг үзүүлэх /эргэн төлөлттэй/	ХБХХЕГ	Төсөл нь шалгарсан аж ахуйн нэгж	Урьдчилгаа 70%, тайлан өгснөөр гүйцэтгэл 30%
		Ажлын байр хадгалах дэмжлэг үзүүлэх	ХБХХЕГ		
4.3	ХБИ-д ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх	Урамшуулал олгох	Аймаг, дүүргийн ХХҮХ	ХБИ-ийг ажилд авсан ажил олгогч	Гүйцэтгэлийн тайлангаар 100%
		Ажлын байрны нөхцөл өөрчилсөн, тохируулга хийсэн зардлыг нөхөх	ХБХХЕГ	ХБИ-ий ажлын байранд тохируулга хийсэн байгууллага	Гүйцэтгэлийн тайлангаар тохирох хувийг
4.4	Ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх	ХБХХЕГ	Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан байгууллага	Гүйцэтгэлийн тайлангаар тохирох хувийг	
4.5	Мэргэжлийн болон давтан сургалт зохион байгуулах	Танхимын сургалт зохион байгуулах	Аймаг, алслагдсан 3 дүүргийн ХХҮХ	Эрх бүхий сургалтын байгууллага	1 иргэнээр, урьдчилгаа 70%, тайлан өгснөөр гүйцэтгэл 30%
		-Үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулах	ХБХХЕГ	Тохируулгатай ажлын байртай, үйлдвэрлэлийн дадлага хийх боломжтой аж ахуйн нэгж	1 иргэнээр, урьдчилгаа 70%, тайлан өгснөөр гүйцэтгэл 30%

4.6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад үйл ажиллагаа	ХТХ-ийн 111 дүгээр зүйл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийх	ХБХХЕГ	Сонгон шалгаруултад тэнцсэн байгууллага	Урьдчилгаа 70%, тайлан өгснөөр гүйцэтгэл 30%
-----	---	---	--------	---	--

Хүснэгт 17. АХМАД НАСТНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

Хөтөлбөрийн арга хэмжээ	Зохион байгуулах, санхүүжилт олгох байгууллага	Гүйцэтгэгч байгууллага	Санхүүжилтийн арга	
5.1	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ зохион байгуулах	Аймаг, дүүргийн ХХҮХ	Ахмад мэргэжилтэн	Гүйцэтгэлийн тайлангаар 100%
5.2.	Ахмадын төрийн бус байгууллагаар зөвлөх үйлчилгээ зохион байгуулах	ХХҮЕГ	Сонгон шалгаруултад тэнцсэн байгууллага	Урьдчилгаа 70%,тайлан өгснөөр гүйцэтгэл 30%
5.3.	Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох	Аймаг, дүүргийн ХХҮХ	Аж ахуй эрхлэгч ахмад	Сонгон шалгаруулалтаар 100%

4.4. ХЭД үйл ажиллагаатай холбоотой тулгамдсан асуудлууд

2012 оноос хойш 10 жилийн хугацаанд ХЭҮЗ-өөс ХЭД хөтөлбөрүүдийг нийт 8 удаа баталжээ. Ингэхдээ зөвхөн 2 удаа ХЭД хөтөлбөрийг өмнөх онд нь баталсан байна (Хүснэгт 18).

Хүснэгт 18. ХЭҮЗ-ӨӨС ХЭД ХӨТӨЛБӨРИЙГ БАТАЛСАН ОГНОО

№	Баталсан огноо	Хөтөлбөрийн тоо	Хэрэгжсэн он	ХЭҮЗ-ийн тогтоолын дугаар
1.	2012.03.12	5	2012	2
2.	2012.12.04	8	2013	4
3.	2014.01.13	10	2014	5
4.	2015.02.12	5	2015	7
5.	2015.12.16	8	2016	8
6.	2017.01.27	6	2017-2018	1
7.	2019.01.14	6	2019-2020	1
8.	2021.02.09	5	2021-2022	1

Эх сурвалж: ХЭҮЗ-ийн тогтоолууд

ХЭД хөтөлбөрийг баталсны дараа хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн сарын хуваарийг аймаг, дүүргээр баталдаг. Хөтөлбөр оройтож батлагдах тохиолдолд, төлөвлөлт, хуваарь оройтож, санхүүжилтийн олголт хоцордог байна. Эдгээр шалтгаан болон улирлын шинж чанартай гадаад ажилтнуудын ажлын байрны төлбөрөөс хамааран ХЭДС-д 3, 4 дүгээр сараас орлогын эх үүсвэртэй болж байгаа нь хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хамгийн том бэрхшээл болж байна. ХЭДС-д улсын төсвөөс олгох хөрөнгийг ихэвчлэн 3 дугаар сараас мөн олгодог байна. ХЭД хөтөлбөрүүдийг 4-5 дугаар сараас хэрэгжүүлж эхлэх үед барилга, зам, газар тариалан гээд улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд хөдөлмөрийн зах зээлээс хүн хүчээ аль хэдийн сонгон авсан байдаг. Нөгөө талаас, ажиллах хүчний эрэлт оны эхний хагаст бий болох хандлага давамгайлдаг. Тухайлбал, ХНХСИ-ээс хийсэн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаагаар 2020 онд бий болох ажиллах хүчний эрэлтийн 81.6 хувь¹¹ нь, 2021 оны ажиллах хүчний эрэлтийн 74.9 хувь¹² нь тус тус тухайн оны эхний хагаст бий болно гэж тооцоолжээ. Хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний эрэлтийг хангах, ажилгүй иргэдийг хөдөлмөрт бэлтгэх, мэргэжлийн сургалт болон хөтөлбөрийн бусад арга хэмжээнүүдэд хамруулах үйл ажиллагааг оны эхнээс буюу 1-3 дугаар сард зохион байгуулах нь цаг хугацааны хувьд оновчтой байна.

Иймд тогтвортой үр дүнтэй хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн хэрэгжих хугацааг уртасгах, хөтөлбөрийн тоог цөөлж зарим хөтөлбөрүүдийг байнгын арга хэмжээ болгох шаардлагатай гэж үзэж байна.

ХЭД хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой дээр дурдсан бэрхшээлтэй асуудлаас гадна ХЭД үйл ажиллагаанд дараах асуудлууд тулгамдаж байна. Үүнд:

	ХЭД хөтөлбөр, арга хэмжээг батлахдаа тэдгээрийг хэрэгжүүлэх хүний нөөц, бүтэц орон тооны асуудлыг давхар шийдэж, цалин хөлс зардлыг төсөвтөө тусгах хэрэгтэй байна.
	ХЭД үйл ажиллагааг сурталчлах арга хэмжээг хангалттай хийдэггүйгээс хөтөлбөр, үйлчилгээний талаарх ойлголт мэдээлэл олон нийтийн дунд хязгаарлагдмал, хэрэгцээ шаардлагатай үйлчлүүлэгчдийн хандалт бага байна.
	ХЭД үйлчилгээ, хөтөлбөрийн хэрэгжилтийн чанар, үр дүнд үнэлгээ тогтмол хийдэггүй. ХЭД хөтөлбөрийн хамрах хүрээ, зорилтот бүлгийг тодорхойлохдоо хөдөлмөрийн зах зээлд нэвтрэхэд зайлшгүй дэмжлэг тусалцаа шаардлагатай бүхий л бүлгийг хамруулахыг зорьдог боловч нарийвчилсан судалгаа, тооцоонд үндэслэдэггүй. ХНХСИ нь хөдөлмөрийн зах зээлийн тойм судалгаа, эрэлтийн судалгаа хийдэг боловч орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн бодлого, зорилго, онцлогт нийцсэн судалгаа хангалтгүй байна.
	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний мэдээллийн түүх ХХҮЕГ-ын Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санд (LMIS) харагддаггүй учраас нэг иргэн олон үйлчилгээнд зэрэг хамрагдах нөхцөл бүрдэж байна.
	Орон нутгийн ХХҮГ/Х-үүд өөрсдийн онцлогт нийцсэн, амжилттай хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн үр дүнг үнэлж, дараагийн төлөвлөлтөд тусгуулах талаар хангалттай идэвх зүтгэл гаргадаггүй. Тухайлбал, НХЭГ-аас үр дүнтэй хэрэгжүүлж байсан “Хүнсний ногоо тариалах хөтөлбөр” 2021 онд хасагдсан, Сэлэнгэ аймагт мэргэжлийн болон давтан сургалтад хамруулах хүний тооны квотыг 200-аас 22 болгож бууруулсан нь олон сумтай аймгийн хувьд хүрэлцээгүй байсан зэрэг шалтгааныг дурдаж болно.


¹¹ Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа. ХНХСИ, 2019

¹² Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа. ХНХСИ, 2020

Иргэн, ААН-д олгох санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд өр, авлага түүнийг барагдуулахтай холбоотой асуудал их үүсч байгаа учраас зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хэмжээг нь нэмэгдүүлэх, хэрэгжилт хариуцсан хүний нөөцийн асуудлыг шийдэх эсхүл Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) зэрэг санхүүгийн байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх шаардлагатай байна.

ААН, ажил олгогчийг дэмжих арга хэмжээг нэмэгдүүлэх, шинээр боловсруулах эрэлт хэрэгцээ өндөр байна. Ихэнх хөтөлбөрийн арга хэмжээ албан бус секторт ажиллагчид, иргэнд чиглэдэг учир ажилгүйдэл, ажиллах хүчний албан ёсны статистик тоонд нөлөөлөх нь бага байдаг. Тиймээс албан бус хөдөлмөр эрхлэлтийг бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

ХЭД хөтөлбөр, арга хэмжээ, үйлчилгээний тарифийн бодит үнэд өөрчлөлт оруулалгүй удсан, зарим нь зах зээлээс доогуур өртөгтэй байна. Жишээ нь, хувийн биржид олгох үйлчилгээний тариф бага учраас ихэнх биржүүдийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсон талаар Хувийн биржүүдийн холбооноос зохион байгуулсан хэлэлцүүлгийн үеэр олон санал гарсан болно.



5.


ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САН

5.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын эх үүсвэр

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан эх үүсвэрүүдээс бүрддэг. ХЭДС-ийн орлогын гол эх үүсвэр нь улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө болон гадаад иргэнийг ажиллуулсан ажил олгогчийн төлөх ажлын байрны төлбөр юм.

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 9.2-т “Ажлын байрны төлбөрийн хэмжээ нь 1 сард гадаадын иргэн бүрд МУ-ын ЗГ-аас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна” гэж заасан байдаг. 2021 оны байдлаар ажлын байрны төлбөр 1 гадаад иргэнд сард 840 мянган төгрөг байна. Түүнчлэн Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дэх хэсэгт “25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулна” гэсэн шаардлагыг хангаагүй аж ахуйн нэгж, байгууллагууд уг хуулийн 111.2-т “... хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлбөр төлнө” гэсний дагуу ХБИ-ийг ажиллаагүйн төлбөрийг ХЭДС-д шилжүүлдэг. Мөн ХЭДС-аас олгосон жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт, зарим онд орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө нь сангийн эх үүсвэр болдог.


Зураг 15. ХЭДС-ИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ, ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР



Эх сурвалж: Сангийн яам, 2021

ХЭДС-ийн орлого 2016-2020 онд нийт дүнгээр төлөвлөснөөс давж биелсэн байна.


Зураг 16: ХЭДС-ИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БА ГҮЙЦЭТГЭЛ, ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР



Эх сурвалж: Сангийн яам

ХЭДС-ийн орлого нийт дүнгээр төлөвлөгөөнөөс давж биелдэг боловч орлогын дийлэнх хувь нь гадаадын иргэнийг ажиллуулсан ажил олгогчийн төлөх ажлын байрны төлбөрийн орлогоос бүрддэг тул төвлөрөх орлогын хэмжээ жилийн турш тэнцвэргүй байна. Тухайлбал, ажлын байрны төлбөрийн орлого нь оны 2 дахь улирал буюу 4 дүгээр сараас эхлэн төвлөрч, 6, 9 дүгээр сард идэвхжин, оны эцэст ажил олгогчид дараа оны ажлын байрны төлбөрийг урьдчилан төлдөгтэй холбоотойгоор орлого өсөх хандлагатай байна. (Зураг 17)

Зураг 17. ХЭДС-ИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ, САРААР, САЯ ТӨГРӨГӨӨР



Эх сурвалж. СЯ-ны Төрийн сангийн газар, 2021 оны 12 дугаар сар

5.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарцуулалт

ХЭДС-ийн хөрөнгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, ХЭД хөтөлбөр болон ХЭҮЗ, ЗГ-ын шийдвэрээр тодорхойсон хөтөлбөр, төсөлд зарцуулдаг.

Зураг 18. ХЭДС-ИЙН ЗАРЛАГЫН ТӨСӨВ, ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР



Эх сурвалж: Сангийн яам

ХЭДС-ийн төсөв 2016-2021 онд 2.2 дахин буюу 49.5 тэрбумаас 109.6 тэрбум төгрөг болж өссөн байна. (Зураг 18) ХЭДС-ийн сүүлийн 5 жилийн зарцуулалтыг харахад ХЭД хөтөлбөрүүдийн төсөв нь хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний төсвөөс 23.8 дахин илүү байна.

Хүснэгт 19. ХЭДС-ИЙН ЗАРЦУУЛАЛТ, ЗОРИУЛАЛТААР, САЯ ТӨГРӨГӨӨР

Зориулалт	2016	2017	2018	2019	2020
Нийтлэг үйлчилгээ	968.2	809.1	1,005.3	1,335.4	637.0
Нийт хөтөлбөр	15,016.7	23,535.3	25,392.8	30,154.4	17,869.0
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад арга хэмжээ	10,552.2	6,920.0	8,362.5	5,549.1	3,702.3
Хүүхэд хамгаалагч төсөл				312.9	239.2
Жижиг зээл		20,000.0	20,000.0		
МСҮТ	10,149.3	2,271.0	2,271.0	18,588.3	54,851.2
НИЙТ ЗАРЦУУЛАЛТ	36,686.4	53,535.4	53,535.4	55,940.1	77,324.6
Төсөв	49,539.0	61,198.0	61,198.0	83,382.4	88,957.2
Гүйцэтгэлийн хувь	74.1%	87.1%	87.1%	67.1%	86.9%

Эх сурвалж: Сангийн яам

Гэхдээ ХЭД хөтөлбөрт хамрагдсан хүний тоо, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамрагдсан хүний тооноос харьцангуй цөөн байна.

Хүснэгт 20. ХЭД ХӨТӨЛБӨР, НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО

Зардлын зориулалт	2016	2017	2018	2019	2020
1 Нийтлэг үйлчилгээ	90,322	149,545	133,066	162,643	84,573
1.1 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ	54,476	103,862	89,961	118,584	51,567
1.2 Ажилд зуучлах үйлчилгээ	35,846	45,683	43,105	44,059	33,006
2 ХЭД хөтөлбөр, арга хэмжээ	48,596	63,324	64,791	74,487	29,127


2.1	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	5,684	9,631	7,677	7,353	2,587
2.2	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	11,690	36,466	38,464	45,728	18,577
2.3	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	19,725	4,281	4,869	8,177	2,637
2.4	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	4,032	4,886	6,637	6,265	1,598
2.5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	4,849	5,782	5,617	5,622	2,844
2.6	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	2,616	2,278	1,527	1,342	884

Эх сурвалж: ХНХЯ, 2021

2015-2021 онд хэрэгжүүлсэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдээс харахад хөтөлбөрүүдийн арга хэмжээ, хамрах хүрээ буюу зорилтот бүлэгт томоохон өөрчлөлт ороогүй байна. Тухайлбал, Нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөр нь 2017 оноос Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт арга хэмжээ байдлаар, 2021 онд Ажлын байрыг дэмжих хөтөлбөр нь Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр болж өөрчлөгдсөн ба уг хөтөлбөрт Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга хэмжээ байдлаар оржээ.

Сүүлийн 5 жилийн байдлаар ХЭДС-ийн нийт төсвийн 52-68 хувь нь Ажлын байрыг дэмжих/Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрт (Зураг 19) хуваарилагджээ.

Зураг 19: ХЭД ХӨТӨЛБӨРИЙН ТӨСӨВ, НИЙТ ХӨТӨЛБӨРИЙН ТӨСӨВТ ЭЗЛЭХ ХУВИАР, 2017-2021 ОН



Ажлын байрыг дэмжих (Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх) хөтөлбөрт хамгийн их төсөв хуваарилж, санхүүгийн дэмжлэг, түрээсийн хөнгөлөлт, ажил олгогчид дэмжлэг олгох арга хэмжээнд гол төлөв зарцуулдаг байна. Тухайлбал, 2021 онд хэрэгжүүлсэн ХЭД хөтөлбөрүүдийн хүрээнд 12.5 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг иргэн, аж ахуй нэгжид үзүүлснээс 7.2 тэрбум төгрөг буюу төсвийн 56 хувь нь Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрийн хүрээнд олгох санхүүгийн дэмжлэгт хуваарилагдсан байна.

Хүснэгт 21. САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГТ 2021 ОНД ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ, САЯ ТӨГРӨГӨӨР

АРГА ХЭМЖЭЭ	Гүйцэтгэл		
	Хүний тоо	Гүйцэтгэл	
1	Иргэнд олгох санхүүгийн дэмжлэг /эргэн төлөлттэй/	1,193	4,723.0
2	Ажил олгогчид олгох дэмжлэг	119	614.2
3	Малчин өрхийг малжуулахад олгох санхүүгийн дэмжлэг	371	1,707.01
4	Борлуулалтын дэмжлэг үзүүлэх арга хэмжээ	409	210.36
5	Хувиараа хөдөлмөр эрхлэгчид олгох санхүүгийн дэмжлэг /50 хувь эргэн төлөлттэй/	704	2,470.68
6	Төрийн бус байгууллагад үзүүлэх санхүүгийн дэмжлэг үзүүлэх /эргэн төлөлтгүй/	-	548.0
7	Аж ахуйн нэгжид үзүүлэх санхүүгийн дэмжлэг /эргэн төлөлттэй/	-	614.0
8	Ажлын байр хадгалах дэмжлэг үзүүлэх	-	164.74
9	ХБИ-нд ажлын байр бий болгосон ажил олгогчид урамшуулал олгох	55	275.39
10	Ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх	215	248.89
11	Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох	375	897.0
12	Нийт санхүүгийн дэмжлэг	3,441	12,473.27
12	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээний нийт зардлын дүн	18,254	18,800.50
13	Нийт санхүүгийн дэмжлэг, урамшуулалд зарцуулсан хөрөнгө, ХЭД хөтөлбөрийн нийт зардалд эзлэх хувиар	19%	66.3%

Эх сурвалж: ХХҮЕГ

Жич: Дээрх арга хэмжээний 1-4 дэхь арга хэмжээ Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр, 5-6 дахь арга хэмжээ нь Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, 7-10 дахь арга хэмжээ нь ХБИ-ний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, 11 дэхь арга хэмжээ нь Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн ба арга хэмжээний нэрийг ХХҮЕГ-аас ирүүлсэн ХЭДС-ийн төсвийн гүйцэтгэлийн мэдээний нэрээр оруулав. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн Шилдэг “Старт-Ап” залуу, залуучуудын багийг сонгон шалгаруулах, Улсын хэмжээнд “Старт-Ап” залуу, залуучуудын багийг сонгон шалгаруулах арга хэмжээнүүдийн хүрээнд олгох дэмжлэгүүдийг /нийт 440.0 сая/ гарааны бизнесийг дэмжих арга хэмжээнд бүлгэлсэн тул санхүүгийн дэмжлэгт оруулаагүй болно.

2017-2021 онд хэрэгжүүлсэн ХЭД хөтөлбөрийн арга хэмжээнүүдийг нийтлэг шинж чанараар нь бүлэглэн дараах 6 багц арга хэмжээнүүдэд хувааж болохоор байна. Үүнд:

- САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ;
- СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУУЛАХ;

- НИЙТИЙГ ХАМАРСАН АЖИЛ, АХМАД МЭРГЭЖИЛТНИЙ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ, БҮЛГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ НОГОО ТАРИАЛАХ;
- ОЮУТНЫГ ЦАГИЙН АЖИЛД БОЛОН ХБИ-НИЙГ ДЭМЖЛЭГТЭЙГЭЭР АЖИЛД ЗУУЧЛАХ;
- ГАРААНЫ БИЗНЕС ЭРХЛЭХИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ;
- БУСАД.


ХЭД хөтөлбөрийн төсвийг дээрх 6 багц арга хэмжээнүүдэд 2017-2021 онд хэрхэн хуваарилснийг хүснэгт 22-д харуулав.

Хүснэгт 22. ХЭД ХӨТӨЛБӨРҮҮДИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

АРГА ХЭМЖЭЭ	2017		2018		2019		2020		2021	
	Төсөв (сая төг.)	Нийт төсөвт ээлэх хувь	Төсөв (сая төг.)	Нийт төсөвт ээлэх хувь	Төсөв (сая төг.)	Нийт төсөвт ээлэх хувь	Төсөв (сая төг.)	Нийт төсөвт ээлэх хувь	Төсөв (сая төг.)	Нийт төсөвт ээлэх хувь
Санхүүгийн дэмжлэг	15,164.1	64.4%	18,710.9	73.7%	22,345.4	74.1%	13,617.9	76.7%	12,473.3	66.3%
Сургалт	1,765.5	7.5%	1,748.7	6.9%	1,789.2	5.9%	507.8	2.9%	862.2	4.6%
Нийтийг хамарсан ажил ба түүнтэй төстэй ажил	6,260.6	26.6%	4,639.9	18.3%	4,532.3	15.0%	3,007.5	16.9%	2,720.9	14.5%
Ажилд зуучлах / цагийн ажил, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах зэрэг/	51.3	0.2%	106.7	0.4%	101.5	0.3%	45.0	0.3%	44.9	0.2%
Гарааны бизнес эрхлэхийг дэмжих арга хэмжээ зохион байгуулах	293.8	1.2%	186.7	0.7%	304.6	1.0%	143.3	0.8%	727.9	3.9%
Бусад	-	0.0%	-	0.0%	1,081.6	3.6%	437.8	2.5%	1,971.2	10.5%
НИЙТ	23,535.3	100%	25,392.8	100%	30,154.6	100%	17,759.2	100%	18,800.5	100%


ХЭД хөтөлбөрүүдийн арга хэмжээний нийт төсвийн 64-77 хувь нь зөвхөн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хуваарилагдаж байсан бол (зураг 20) төсвийн 14.5-27 хувь нь нийтийг хамарсан ажилд, төсвийн дөнгөж 3-7.5 хувь нь сургалтын арга хэмжээнд зарцуулагджээ. Дэлхий нийтээр тохиолдсон цар тахлын нөлөөнөөс болж ХЭД хөтөлбөрийн нийт зардал 2019-2021 онд буурчээ.

Зураг 20. ХЭД ХӨТӨЛБӨРИЙН НИЙТ ТӨСӨВТ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, 2017-2021



ХЭД хөтөлбөр, зарим арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байдгаас шалтгаалсан ХЭДС-ийн нийт зарлагын төсвийн гүйцэтгэл сүүлийн 5 жилийн дунджаар жилд 78.5 хувь байна. ХЭД сангийн зарлагын гүйцэтгэл төлөвлөснөөс доогуур байхад нөлөөлдөг гол хүчин зүйл нь ХЭДС-ийн орлого хоцорч бүрдсэнээс зарцуулж амждаггүйтэй холбоотой байдаг.

Зураг 21. ХЭДС-ИЙН ЗАРЛАГЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР



Түүнчлэн сангийн зарлагын төсвийн гүйцэтгэл доогуур байхад дараах хүчин зүйл нөлөөлж байна:

- Сангийн орлогын гол эх үүсвэр болох гадаад иргэдийн ажлын байрны төлбөрийн орлогын бүрдүүлэлт жилийн зарим саруудад илүү төвлөрдөг учраас жилийн турш жигд зарцуулалт хийх боломжгүй байх;
- Урьд оны үлдэгдлийг санд шилжүүлэх санхүүжилтийн эрх нээгдэхгүй уддаг (ихэвчлэн 3-4 дүгээр сард санхүүжилт хийгддэг);
- ХЭДС-аас санхүүжүүлэх ХЭД хөтөлбөрийг жил бүр (зарим үед 2 жилд 1 удаа) ХЭҮЗ-өөс шинэчлэн баталдаг. Хөтөлбөрийг ихэвчлэн он гарсны дараа баталдаг бөгөөд түүний дараа хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвийн хуваарийг батлах учраас жилийн эхний саруудад хөтөлбөрүүдэд төсөв зарцуулагддаггүй;

- Тухайн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зарим хөтөлбөрүүдийг дагаж гарах журам, заавар батлагдахгүй удах зэргээс шалтгаалж хөтөлбөрийн хэрэгжиж эхлэх хугацаа хойшлох тохиолдол гардаг;
- Зарим шинэ хөтөлбөр, арга хэмжээ нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэхгүй байх эсхүл хөтөлбөрийн талаар хангалттай мэдээлэл түгээгээгүйгээс хөтөлбөрт иргэд хамрагдахгүй байна. Тухайлбал, 2020 онд НХЭГ-т ХЭДС-аас хуваарилагдсан төсвийн 47.8 хувь нь Гэрээт малчин хөтөлбөрт тавигдсан боловч хөтөлбөрт хамрагдах хүн цөөн байснаас зарцуулалтын гүйцэтгэл бага хувьтай гарсан. Хэдийгээр ХЭҮЗ-ийн хурлаар төсвийг өөр хөтөлбөрт шилжүүлж болох байсан ч цаг хугацааны хувьд өөр арга хэмжээ хэрэгжүүлэх боломжгүй болсон учраас тухайн жилийн гүйцэтгэл доогуур гарсан нь мөн дараа оны төлөвлөлтөд нөлөөлжээ.

5.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтийн зарчим, төрийн сангийн гүйлгээ

ХЭҮЗ тухайн жилд хэрэгжүүлэх ХЭД хөтөлбөрүүдийг оны эхний сард хуралдан баталж, хөтөлбөр тус бүрээр төсөв, хамрагдах хүний тоог хэлэлцэнэ. Тухайн хөтөлбөрт хамрагдах хүний тоо, төсвийг нэгжүүдийн хүн амын тоо, ажилгүй иргэдийн тоо, тухайн нэгжээс төсвийн төлөвлөлтийн үеэр ирүүлсэн санал болон бусад хүчин зүйлсэд үндэслэн хуваарилдаг. Үйлчилгээ, хөтөлбөрийн төрөл, хуваарилагдсан төсөв, хөтөлбөрт хамрагдах хүний тоо зэргээс хамаарч аймаг, дүүргийн ХХҮХ-үүд зарим үйл ажиллагааг өөрийн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлж ихэнх арга хэмжээг бусад байгууллагуудтай гэрээ байгуулан гүйцэтгүүлдэг.


ААН, ТББ, Хувийн биржүүдтэй гэрээ байгуулахдаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 6 дугаар сарын 18-ний өдрийн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тушаалд гэрээний үнийн дүнг тогтоож байна. ХЭД үйлчилгээ, хөтөлбөрийн арга хэмжээний нэгжид ногдох зардлыг тогтоосон тушаалыг 2021 онд шинэчлэн баталсан ч зардлын (тарифын) дүнд өөрчлөлт ороогүй зөвхөн зарим тарифт хамаарах арга хэмжээнд өөрчлөлт оруулан баталсан байна. Зардлын жишиг тарифыг зах зээлийн үнэ ханштай уялдуулан шинэчлэхгүй байх нь ХЭД хөтөлбөр, нийтлэг үйлчилгээний санхүүжилт хүрэлцэхгүй байх эрсдэл үүсгэж байна. Жишээ нь: Сургалтын байгууллага нь мэргэжлийн болон давтан сургалт явуулах эрх авахын тулд суралцагчийг тоног төхөөрөмж дээр дадлагажуулах нөхцөлийг бүрдүүлсэн байх шаардлага тавигддаг. Гэвч ХЭДС-ийн санхүүжилтээр сургалт явуулаад олсон орлого нь дадлагын тоног төхөөрөмжийн ашиглалтын зардлыг нөхөхгүй байх тохиолдол ч гардаг байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөтөлбөрийн арга хэмжээг зохион байгуулсан байгууллагад санхүүжилт олгохдоо гэрээ байгуулснаар урьдчилгаа 70 хувь, гүйцэтгэлийн тайлан өгснөөр үлдэгдэл 30 хувийн санхүүжилт өгөх, гүйцэтгэлд тулгуурлан 100 хувь санхүүжилт өгөх гэсэн үндсэн 2 зарчмаар санхүүжилтийг олгож байна. Цөөн тохиолдолд гэрээний үнийн дүнгээр санхүүжилт олгодог. Гүйцэтгэлд тулгуурлан 100 хувь санхүүжилт олгох арга хэмжээнүүдэд санхүүгийн дэмжлэг, урамшуулал, хувийн хөдөлмөрийн биржүүдийн ажилд зуучлах үйлчилгээ, нийтийг хамарсан ажил болон ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулах арга хэмжээ хамаарна.


Бусад арга хэмжээнүүдэд урьдчилгаа 70 хувь, гүйцэтгэл 30 хувь гэсэн зарчмаар санхүүжилтийг олгодог байна. Гэвч зарим тохиолдолд гэрээний үлдэгдэл санхүүжилт авах процессын төвөгтэй байдлаас шалтгаалан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээг тасралтгүй, чанартай хүргэхэд саад болдог байна.

Тухайлбал, мэргэжлийн болон давтан сургалт зохион байгуулсан эрх бүхий сургалтын байгууллага гэрээний үлдэгдэл санхүүжилтээ авахын тулд төгсгөсөн суралцагчдын тодорхой хувийн чадамжийг баталгаажуулсан байх шаардлагатай байдаг. Ингэхдээ Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл арга зүйн төв нь төгсөгчдөөс түүвэр байдлаар мэргэжлийн шалгалт авч, тэнцсэн тохиолдолд суралцагчдад чадамжийн гэрчилгээ олгоно. Сургалтын байгууллага нь төгсөгчдөд олгосон чадамжийн гэрчилгээг

Зураг 22: МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ДАВТАН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ ЯВЦ



тайландаа хавсарган үлдэгдэл санхүүжилт авах хүсэлтээ НХЭГ эсхүл гэрээ байгуулсан аймаг, дүүргийн ХХҮХ-т гаргахад, тухайн газраас гэрээг дүгнэж, үлдэгдэл санхүүжилтийг олгоно. Эрх бүхий сургалтын байгууллага сургалт зохион байгуулж дууссанаас хойш энэ процессийн дагуу үлдэгдэл санхүүжилтээ авахад 1 сар зарцуулах тохиолдол гардаг байна.¹³ Мэргэжлийн сургалт, давтан сургалт зохион байгуулах үйл ажиллагаа, санхүүжилт олгох дэлгэрэнгүй үйл явцын зураглалыг доорх зураг 22-д оруулав.




Эх сурвалж: ДБ-ны санхүүгийн дэмжлэгээр хэрэгжиж буй "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл"-ийн зөвлөхүүдийн тайлан.

¹³ НХЭГ-ийн албаны дарга, мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлага, 2021 оны 11 дүгээр сар. Уулзсан хүмүүсийн нэрсийг энэхүү тайлангийн хавсралтад оруулсан болно.

ХЭДС-аас анхан шатны нэгжүүд буюу аймаг, дүүргийн ХХҮГ/Х-т санхүүжилт хуваарилагдах үйл явцыг дараах зураг 23-д харуулав.

Зураг 23. ХЭДС-ААС АНХАН ШАТНЫ НЭГЖҮҮДЭД САНХҮҮЖИЛТ ХИЙХ ҮЙЛ ЯВЦ



5.4. ХЭД сангийн төсвийн хуваарилалт

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг 2021 онд хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн төсөв, түүний гүйцэтгэлийг аймгуудаар хүснэгт 23-д харуулав.

Хүснэгт 23. ХЭДС-ИЙН 2021 ОНЫ ТӨСВИЙН ХУВААРЬ, ГҮЙЦЭТГЭЛ (МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	Аймаг	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
1	АРХАНГАЙ	626,088.0	601,780.86	96.1%
2	БАЯН-ӨЛГИЙ	600,982.0	547,033.25	91.0%
3	БАЯНХОНГОР	585,301.0	585,074.70	100.0%
4	БУЛГАН	457,418.0	426,007.19	93.1%
5	ГОВЬ-АЛТАЙ	503,789.0	467,172.72	92.7%
6	ДОРНОГОВЬ	445,471.2	372,024.37	83.5%
7	ДОРНОД	688,446.0	639,819.00	92.9%
8	ДУНДГОВЬ	427,228.0	395,819.76	92.6%
9	ЗАВХАН	619,646.0	552,383.51	89.1%
10	ӨВӨРХАНГАЙ	666,864.0	579,731.30	86.9%
11	ӨМНӨГОВЬ	403,801.0	378,562.40	93.7%
12	СҮХБААТАР	450,335.6	417,015.35	92.6%
13	СЭЛЭНГЭ	570,556.0	528,582.77	92.6%
14	ТӨВ	641,295.4	550,342.00	85.8%
15	УВС	654,055.4	590,314.12	90.3%
16	ХОВД	737,862.0	708,175.66	96.0%
17	ХӨВСГӨЛ	779,476.0	729,377.38	93.6%
18	ХЭНТИЙ	663,561.0	576,682.89	86.9%
19	ДАРХАН-УУЛ	479,154.0	466,777.51	97.4%
20	ОРХОН	556,848.0	530,649.14	95.3%
21	ГОВЬСҮМБЭР	279,401.0	235,344.71	84.2%
22	БАГАНУУР	349,610.0	305,756.65	87.5%
23	БАГАХАНГАЙ	204,586.0	136,608.00	66.8%
24	НАЛАЙХ	378,213.0	324,863.40	85.9%
25	БАЯНГОЛ	696,256.0	572,409.71	82.2%
26	БАЯНЗҮРХ	955,642.0	861,570.00	90.2%
27	СОНГИНОХАЙРХАН	1,118,248.0	1,021,182.00	91.3%
28	СҮХБААТАР ДҮҮРЭГ	561,859.0	421,725.00	75.1%
29	ХАН-УУЛ	631,526.0	590,322.27	93.5%
30	ЧИНГЭЛТЭЙ	665,172.0	607,854.25	91.4%
31	НИЙСЛЭЛИЙН ХЭГ	924,677.0	459,834.38	49.7%
	НИЙТ	18,323,367.6	16,180,796.25	88.3%

ЗГ-ын 2011 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн 375 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 4.7-д “Сангийн батлагдсан төсвийг аймаг, нийслэл, дүүрэгт хуваарилахдаа хүн амын тоо, ажилгүйдэл, ядуурлын түвшин, хамрагдах хүний тоо зэргийг үндэслэн аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын саналыг харгалзан, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална. ...” гэж заасан байна. Гэвч одоогоор ХХҮЕГ-аас аймгуудын төсвийг хуваарилахдаа тухайн онд хэрэгжүүлэх ХЭД хөтөлбөрийг баталсны дараа тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд хамруулах хүний квот, төсвийн саналыг орон нутгуудаас авч саналыг харгалзан нийт батлагдсан төсвийн хүрээнд багтаан хуваарийг хийж байна.

ХЭДС-ийн 2021 оны төсвийн хуваарийг дээрх журамд дурдсан статистик тоо мэдээтэй харьцуулан үзэхэд дараах шинж чанартай байна. Үүнд:

Эх сурвалж: ХНХЯ

Хүн амын тоогоор ойролцоо аймаг, дүүргүүдийн төсвийг харьцуулахад хүн амын тооноос хамаарсан хамаарал бага байна.

Хүснэгт 24. АЙМАГ, ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ХАРЬЦУУЛАЛТ - ХҮН АМЫН ТООГООР

Аймаг / Дүүрэг	Хүн амын тоо /2021 эхний хагас жил/	Төсөв /2021 оны төсөв – мянган төгрөг/
СЭЛЭНГЭ	108,370	570,556.00
ДАРХАН-УУЛ	103,580	479,154.00
ОРХОН	105,361	556,848.00
БАЯНЗҮРХ	372,760	955,642.00
СОНГИНОХАЙРХАН	340,272	1,118,248.00

Ажилгүйдлийн түвшин ойролцоо аймаг, дүүргүүдийн төсвийг харьцуулахад ажилгүй иргэдийн тооноос тухайн нэгжид хуваарилагдсан төсөв төдийлөн хамааралгүй байна.

Хүснэгт 25. АЙМАГ, ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ХАРЬЦУУЛАЛТ - АЖИЛГҮЙЧДИЙН ТООГООР

Аймаг/ Дүүрэг	Ажилгүйчүүдийн тоо /2021 он/	Төсөв /2021 оны төсөв – мянган төгрөг/
БАЯН-ӨЛГИЙ	4,689	600,982.00
БУЛГАН	229	457,418.00
ДОРНОД	1,272	688,446.00
ӨВӨРХАНГАЙ	2,450	666,864.00
СОНГИНОХАЙРХАН	3,577	1,118,248.00
ХАН-УУЛ	3,342	631,526.00

Зөвхөн аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын санал болон урьд оны төсвийн хуваарийг харгалзан ХЭДС-ийн төсвийг хуваарилах нь тухайн орон нутагт ХЭД үйлчилгээ, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг шударгаар хуваарилах үндэс болохгүй байна. Цаашид тухайн орон нутгийн бодит хэрэгцээ, ажилгүйчүүдийн тоо, ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй өрх, иргэний тоо, ажиллагчдын тоо зэргийг харгалзан ХЭДС-ийн төсвийг хуваарилах тодорхой аргачлалтай болох шаардлагатай байна.

5.5. ХЭДС-аас ХЭД үйлчилгээ, арга хэмжээг санхүүжүүлэх жишиг зардал

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, үйлчилгээг ХНХ-ын сайдын тушаалаар баталсан тарифын дагуу санхүүжүүлдэг ба уг тарифыг 2021 оны 6 дугаар сарын 18-ний өдөр “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” А/96 тоот тушаалаар шинэчлэн баталсан. Ингэхдээ жишиг зардлын (тарифын) хэмжээнд өөрчлөлт оруулалгүй зарим тарифт хамаарах арга хэмжээнд өөрчлөлт оруулан баталжээ.

Сүүлийн 5 жилийн хугацаанд улсын дундаж цалин болон өргөн хэрэглээний барааны үнийн өсөлттэй байсан хэдий ч тарифын хэмжээг хэвээр хадгалснаас зардал хүрэлцээгүй байх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаа зогсонги болох, үйлчилгээ үзүүлэх идэвх буурах эрсдэлтэй байна.

ХНХЯ-ны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, хэлтсийн дарга нараас хүсэлт гаргасны дагуу манай зөвлөх баг нь ХЭД үйлчилгээ, арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоох талаар санал боловсруулж, тооцоолол хийсэн болно. Тарифыг шинэчлэн боловсруулахдаа дараах санал, үндэслэлд тулгуурлав:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ үзүүлж байгаа 25 байгууллага, катеринг үйлчилгээ үзүүлэгч 3 байгууллагаас цахимаар болон утсаар санал авсан;
2. Тухайн үйлчилгээ, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөц (ажлын цаг, дундаж цалин), сургалтын хэрэглэгдэхүүн, бичиг хэргийн болон хэвлэх, хувилах, мэдээлэл сурталчилгаа хийх зэрэг ажлын өртгийг тооцсон;
3. Бусад хууль журмаар баталсан хүчин төгөлдөр мөрдөж буй нормативт зардлыг мөрдсөн;
4. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээс ирүүлсэн саналыг тусгасан.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөхөд гарч буй бодит зардлын судалгааг үйлчилгээ үзүүлж буй эрх бүхий сургалтын 25 байгууллагын дунд явуулахад дараах үр дүн гарав. Үүнд:

- а) Эрх бүхий сургалтын байгууллагууд иргэнд ажилд ороход шаардлагатай ур чадвар, хөдөлмөрийн харилцаа, ажлын байрны харилцааны мэдлэг олгох, мэргэжил сонголт, хувь хүний хөгжлийн чиглэлээр зөвлөгөө, сургалтыг бүлгийн болон ганцаарчилсан хэлбэрээр зохион байгуулдаг;
- б) Үйлчилгээг ганцаарчилсан хэлбэрээр үзүүлэхэд нэг хүнд зарцуулах дундаж хугацааг нийт судалгаанд оролцогчдын 60 хувь нь 40-өөс дээш минут, 32 хувь нь 20-40 минут, 8 хувь нь түүнээс богино байхаар тодорхойлсон;
- в) Харин бүлэгт үзүүлэх зөвлөгөө, сургалтыг 12 хувь нь 10 хүртэл минут, 40 хувь нь 11-15 минут, 24 хувь нь 16-20 минут, 4 хувь нь 21-25 минут, 12 хувь нь 26-30 минут, 8 хувь нь 51 ба түүнээс дээш минут үргэлжилдэг гэж үзсэн;
- г) Үйлчилгээг үзүүлдэг ажилтны сарын дундаж цалин нь 800.0-1,000 мянган төгрөгийн хооронд байна;
- д) Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэхэд гарын авлага, анкет, хувь хүний хөгжлийн тестүүд, үнэлгээний хуудас, хамтарсан төлөвлөгөөний загвар, ажлын байрны жагсаалт танилцуулага, нэрийн хуудас, бүртгэлийн хуудас, цавуу, цаас, компьютер, принтер, кофе цай, чихэр зэрэг хэрэглэгдэхүүнүүд шаардагддаг байна.

Аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт багтсан аж ахуй эрхлэлтийн сургалтын хүрээнд эрх бүхий сургалтын байгууллагууд дараах сургалтыг явуулдаг. Үүнд:

1. ОУХБ-ын хөтөлбөрүүдээр сургагч багшийн эрх авна. Тоглоомын багц 89.0 мянган төгрөг

- SYIB Бизнесээ эхэл /Төсөл бичих сургалт/
- Бизнесээ хөгжүүл
- Бизнесийн санаа хөгжүүлэх
- Ногоон бизнес эрхлэх боломж сургалт багтана.

2. ISO 21500 MNS төслийн стандартын дагуу төсөл боловсруулах сургалт;

3. Бүлэг зохион байгуулах сургалт;

4. Хоршооны сургалт;

5. Маркетинг борлуулалтын сургалт.

Эдгээр сургалтад Бизнес хөгжлийг дэмжих төвүүд, Аж ахуй эрхлэлтийн сургалтын төвүүд, Бизнес инкубатор төвүүдээс сургагч багшийн эрх авсан багш хичээл орох ба сургалтын үргэлжлэх дундаж хугацаа 3-5 хоног байдаг. Дээрх сургалтуудад жишиг тоглоомын багц (ILO-ын багц, 89.0 мянган төгрөг), бичгийн цаас, фломастер, өнгийн цаас, бичгийн цаас, ажлын цаас, тодруулагч маркерууд, стикерүүд зэрэг, төсөл бичихэд шаардагдах бичиг хэргийн хэрэгслүүд, компьютер, принтер, проектор зэрэг хэрэглэгдэхүүнүүд ашигладаг байна.

Эдгээр мэдээлэлд үндэслэн ХЭДС-аас санхүүжилт олгоход баримтлах ХЭД үйлчилгээ, хөтөлбөр арга хэмжээний жишиг зардлын тодорхой хэсгийг нэмэгдүүлэх, хэвээр үлдээх саналыг боловсруулсан болно.

1. Жишиг зардлуудыг дараах байдлаар өөрчлөхөөр тооцоолол хийв. Үүнд:

- а)** Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний тарифыг 6-7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх;
- б)** Аж ахуй эрхлэлтийн сургалтын зардлыг 15 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх;
- в)** Хувь хүний бэлтгэл хангах зардлыг 18 мянган төгрөгөөр бууруулах.

Дээрх зардлыг өөрчлөх гол үндэслэл нь сургалтын хэрэглэгдэхүүн, суралцагчийн гарын авлага, дасгал ажлын материалын зардлыг оруулан тооцсон ба хувийн хэвшлийн байгууллагаар АМЧБ олгох болон ажилд зуучлах үйлчилгээг гүйцэтгүүлэх тохиолдолд мөрдөх жишгийг тооцсон болно.

2. Дараах жишиг зардлуудыг хэвээр мөрдөхөөр санал оруулав. Үүнд:

- а)** ХХҮХ-д олгодог ажилд зуучлах үйлчилгээний зардлыг (7000 төгрөг) хэвээр мөрдөх. Учир нь профайлинг үйлчилгээг нэвтрүүлэхтэй уялдуулан ХХҮХ-т олгох зардлыг цаашид илүү үндэслэлтэй тооцох нь зүйтэй байна;
- б)** Нийтийг хамарсан ажил зохион байгуулах зардлыг (3500 төгрөг) хэвээр мөрдөх. Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын гадна талбайн ажилчдын цалингийн хэмжээг жишиг болгон цагийн хөлсийг тооцоход 3270 буюу 3500-аас бага байсан. Гэхдээ орон нутгийн ХХҮГ-уудаас ХХҮЕГ-т ирүүлсэн санал, ЧД-ийн ХХҮХ-ийн саналд үндэслэн нийтийг хамарсан ажил зохион байгуулах хугацааг 14 хоног болгон нэмэгдүүлэх, шаардлагатай тохиолдолд 7 хоногоор сунгадаг байхаар хөтөлбөрт тусгах саналтай байна.

Жишиг зардлыг шинэчлэн тогтоох тооцоолол хийх үед дараах зардлуудыг тодорхойлох боломжгүй байна. Үүнд:

1. Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн арга хэмжээнд тусгагдсан зөөлөн ур чадварын болон мэргэжлийн (онолын) сургалтын зардал;
2. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт орсон богино хугацааны мэргэжлийн болон цахим ур чадвар эзэмшүүлэх сургалтын зардал.

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл арга зүйн төвийн хөтөлбөрийн дагуу эдгээр сургалтуудыг явуулахаар заасан. Тус төвд бүртгэлтэй 1500 гаруй сургалтын төв байдгаас 290 гаруй сургалтын байгууллага нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг боловч суурь чадамж эзэмшүүлэх чиглэлээр сургалт явуулахаар бүртгүүлсэн сургалтын байгууллага байхгүй байна. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт богино хугацааны мэргэжлийн болон цахим ур чадвар эзэмшүүлэх сургалтуудыг мэргэшлийн 2 дугаар түвшний чадамжийг олгох сургалтын хөтөлбөрөөр зохион байгуулахаар заасан. Гэхдээ мэргэшлийн 2 дугаар түвшний чадамжийг олгох сургалт доод тал нь 2 долоо хоног үргэлжлэх ба 7 хоногт 20-иос доошгүй цагийн хөтөлбөртэй байна. Иймд зөөлөн ур чадварын сургалт болон мэргэжлийн онолын сургалтын хөтөлбөр байхгүй эсхүл эцэслэн батлагдаагүй учир эдгээр сургалтын жишиг зардлын хэмжээг тооцоолох боломжгүй байна. Богино хугацааны ур чадвар эзэмшүүлэх сургалтуудын хувьд уг сургалтаар ямар чадамжийг эзэмшүүлэхийг зорьж байгааг хөтөлбөрт тодорхой заах шаардлагатай байна.

ХЭД үйлчилгээ, арга хэмжээний зардлын жишиг хэмжээг шинэчлэн тогтоосон саналыг энэхүү тайлангийн Хавсралтад оруулав.

5.6. ХЭДС-ийн санхүүгийн тайлагналт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1-д Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тайлан, тэнцэл гаргах хугацааг дараах байдлаар зохицуулсан байна. Үүнд:

*"...**25.1.1** Улирлын тайланг дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан аймгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад дараа улирлын эхний сарын 5-ны өдрийн дотор, аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад;*

***25.1.2** Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улирлын нэгдсэн тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, нийгмийн даатгалын төв байгууллагад хүргүүлнэ."*

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бүртгэл, тайлангийн маягтын загварыг санхүү, төсвийн болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална" гэж заасан байдаг боловч одоогоор Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388

тоот тушаалаар баталсан төсөвт байгууллагад мөрдөх санхүүгийн тайлан, тодруулгын маягтын дагуу ХЭДС-ийн санхүүгийн тайлан, мэдээг гаргаж байна.

ХЭДС-ийн үйл ажиллагаанд дараах программ хангамжуудыг ашиглаж байна:

- **Fiscal** – ХЭДС-ийн төсөв нь хөтөлбөр бүрийн нийт дүнгээр, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ тус бүрээр, ХЭҮЗ-ийн гишүүдийн ажлын хөлс, ХЭД бусад хөтөлбөр гэсэн байдлаар Сангийн яамны төсвийн Fiscal программд шивэгддэг.
- **FreeBalance** – Аймаг, дүүрэг, нийслэлийн хөдөлмөрийн эрхлэлтийн байгууллагуудад санхүүжилтийн эрх нээх, гүйлгээ хийх программыг ашигладаг.
- **Explorer, Талст** - Энэ программд ХЭД хөтөлбөр, нийтлэг үйлчилгээний зардлын төсөв, гүйцэтгэлийг хөтөлбөр, арга хэмжээгээр хүний тооны хамт бүртгэдэг. Дээрх программуудаас тайлан мэдээг хөтөлбөр бүрийн хүрээнд гарсан зардлын гүйцэтгэлийг, хамрагдсан хүний тооны хамт эсхүл Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 тоот тушаалаар батлагдсан санхүүгийн тайлан, тодруулгын маягтын дагуу гэсэн 2 янзаар татах боломжтой. Түүнчлэн санхүүгийн дэмжлэг олгосон иргэн, аж ахуйн нэгжийн мэдээлэл дэлгэрэнгүй гарах боломжтой ба цаашид санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн хуваарийг иргэний гар утсанд мессэжээр мэдэгддэг байхаар программын хөгжүүлэлт хийж, 2022 онд туршихаар төлөвлөж байна. Дээрх 2 программыг одоогоор зөвхөн хөдөлмөрийн эрхлэлтийн байгууллагуудын дотоод хэрэгцээнд ашиглаж байна.

E-balance, e-tailan – ХЭДС-ийн тайлан нь ХНХ-ын салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн (ХНХЯ) багцад нэгтгэгддэг.

ХЭДС-ийн төсвийг батлах, хуваарилах, санхүүжүүлэх өнөөгийн процессыг сайжруулахын тулд эхний ээлжинд дараах асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай байна. Үүнд:

- 1) ХЭД сангийн нийт төсвийг УИХ-аас баталсны дараа ХЭҮЗ нь оны дараа хуралдаж, төсөв зарцуулах хөтөлбөр, арга хэмжээ, хуваарийг баталдаг нь хөтөлбөр хэрэгжиж эхлэх хугацаа, нэгжүүд хөтөлбөрт тулгуурласан санхүүжилтийг хүлээн авах хугацаа зэргийг удаашруулж байна. Иймд ХЭҮЗ оны өмнө буюу 11 ба 12 дугаар сард хуралдаж, хөтөлбөр, төсвийн хуваарийг батлах нь зүйтэй.
- 2) ХЭД хөтөлбөрүүдийг жил бүр шинэчлэн баталдаг учраас хөтөлбөрийн тогтворгүй байдал нь зарим арга хэмжээг үр дүнгүй болгох эрсдэлтэй байна. Иймд ихэнх хөтөлбөрт багтдаг байнга хэрэгждэг арга хэмжээнүүдийг хөтөлбөрөөс салгаж, байнгын арга хэмжээ болгон төсөв хуваарилдаг болох. Хөтөлбөрүүдийн арга хэмжээний агуулга, давхардал, хийдлийн асуудлыг бодлогын зөвлөхүүд судалж, үнэлгээний тайланг тусад нь боловсруулан гаргасан болно.
- 3) Оны эхний улиралд ХЭДС-ийн орлогын гол үүсвэр нь сангийн урьд оны үлдэгдэл болдог. Урьд оны үлдэгдлийг санд байршуулах санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтээ СЯ-нд илгээхэд санхүүжилтийн эрх нээхгүй байх тохиолдол гардаг. Энэ асуудлыг СЯ-ны Төрийн сангийн газартай зөвшилцөн, шаардлагатай арга хэмжээг авч шийдвэрлэх.
- 4) НХЭГ, аймаг, дүүргийн ХХҮХ-үүдэд санхүүжилтийг төрийн сангийн нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан олгодог. Энэ нь төрийн сангийн гүйлгээний тогтолцооноос хамаарч санхүүжилт удаашрах нэг шалтгаан болж байна. Түүнчлэн нэмэлт санхүүжилтийн дансаар санхүүжилт олгох нь тайлан мэдээ гаргах, нэгтгэхэд заавал нэмэлт тохируулга шаарддаг байна. Иймд үндсэн дансаар санхүүжилт хийх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.

- 5) ХЭДС-ийн төсвийг хуваарилж байгаа одоогийн нөхцөл нь тухайн орон нутагт ХЭД үйлчилгээ, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг шударгаар хуваарилах үндэс болохгүй байна. Цаашид тухайн орон нутгийн бодит хэрэгцээ, ажилгүйчүүдийн тоо, ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй өрх, иргэний тоо, ажиллагчдын тоо зэргийг харгалзан ХЭДС-ийн төсвийг хуваарилах тодорхой аргачлалтай болох шаардлагатай юм.

5.7. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгодог жижиг зээл, санхүүгийн дэмжлэг

ЖИЖИГ ЗЭЭЛ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.2, 12.7 дахь заалт Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 340 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг баримтлан хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчинд 10.0 хүртэл сая төгрөгийн, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэнд 25.0 хүртэл сая төгрөгийн, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид 50.0 хүртэл сая төгрөгийн 24 сарын хугацаатай жижиг зээлийг арилжааны банкаар дамжуулан олгож байна.

Жижиг зээлийг арилжааны банкуудаар дамжуулан олгох ба жижиг зээл авагч нь зээлийн мөнгөн дүнгийн 40 хувьд хүрэлцэхүйц барьцаа хөрөнгөтэй байх нөхцөлтэй. Жижиг зээл авсан хүний тоо, хөрөнгийг хүснэгт 26-д харуулав.


Хүснэгт 26. ХЭДС-ААС ОЛГОСОН ЖИЖИГ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ, ТӨГРӨГӨӨР

Банкууд	Он	Эх үүсвэрийн дүн		Олгосон зээлийн хэмжээ		Зээлийн эргэн төлөлтөөс олгосон хэмжээ
		Санхүүжилт	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн төг.	
ГОЛОМТ БАНК	2017	ХЭДС	20,000,000,000	1,780	20,851,530,000	851,530,000
Дүн			20,000,000,000	1,780		
ТӨРИЙН БАНК	2018	ХЭДС	6,900,000,000	936	7,984,574,000	1,084,574,000
ХААН БАНК	2018	ХЭДС	9,000,000,000	1,037	10,331,682,675	1,331,682,675
Дүн			15,900,000,000	1,973	18,316,256,675	
ТӨРИЙН БАНК	2019	Дэлхийн банк	3,990,000,000	496	4,447,272,000	457,272,000
ХААН БАНК	2019	Дэлхийн банк	4,010,000,000	514	4,504,300,000	494,300,000
Дүн			8,000,000,000	1,010	8,951,572,000	
ТӨРИЙН БАНК	2020	Дэлхийн банк	1,091,880,000	85	802,500,000	
ХААН БАНК	2020	Дэлхийн банк	1,132,620,000	44	395,900,000	
Дүн			2,224,500,000	129	1,198,400,000	
НИЙТ ДҮН			46,124,500,000	4892	49,317,758,675	4,219,358,675

Эх сурвалж: ХНХЯ, 2021

Жижиг зээл хүссэн иргэн, ААН-ийн боловсруулсан төслийг Аймаг, дүүргийн ХХҮГ/Х сонгон шалгаруулж арилжааны банкинд хүргүүлэхэд арилжааны банк тухайн зээл хүсэгчид зээл олгох эсэх эцсийн шийдвэр гаргаж, зээлийн эргэн төлөлтийг хариуцдаг. Арилжааны банкинд жижиг зээлийн эх үүсвэрийг удаан хугацаанд байршуулахад зээл олголтын явц удаашрах нөхцөл үүсдэг ч зээлийн эргэн төлөлт хийгдэхгүй байх эрсдэлийг банк үүрдэг давуу талтай байна.

Зураг 24. АРИЛЖААНЫ БАНКААР ДАМЖУУЛАН ЖИЖИГ ЗЭЭЛ ОЛГОХ ҮЙЛ ЯВЦ



ХЭД хөтөлбөрүүдийн хүрээнд үзүүлдэг 36 хүртэл сарын (2022 оноос 48 хүртэл сар) санхүүгийн дэмжлэг нь хамгийн эрэлттэй арга хэмжээ болдог. Санхүүгийн дэмжлэг нь хүүгүй, барьцаагүй учир иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил, жижиг бизнес эрхлэгч ААН-үүдэд бодитой туслалцаа болж чаддаг. 2021 оны байдлаар ХЭДС-аас дараах санхүүгийн дэмжлэгийг НХЭГ, аймаг, дүүргийн ХХҮГ-ээр дамжуулан олгосон. Үүнд:

1. Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрийн хүрээнд:

- Иргэн, ААН-д 5.0 хүртэлх сая төгрөгийн эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг;
- Богино хугацааны 150-500 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийн дэмжлэг (Fintech);
- Малчин өрхийг малжуулах 4-5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг;
- Гэрээт малчин өрхийг малжуулах 3 хүртэлх сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг.

2. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:

- Шилдэг “Старт-Ап” залуу, залуучуудын багийг сонгон шалгаруулж урамшуулах-Ялагч багт 10.0 сая төгрөг (эргэн төлөлтгүй);
- Улсын хэмжээнд “Старт-Ап” залуу, залуучуудын багийг сонгон шалгаруулж урамшуулах-Ялагч багт 13.0– 20.0 сая төгрөг (эргэн төлөлтгүй).

3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:

- ХБИ эсхүл Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд (ХБХ)-ээ асардаг эцэг, эхийн ажлын байр бий болгох төсөлд олгох 3-5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг (50 хувь эргэн төлөлттэй);
- ТББ-ийн төсөлд ХБИ-ний 1 ажлын байранд 5 сая төгрөгийн, нийтдээ 20 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг (эргэн төлөлтгүй);
- ХБИ-ний эсхүл ажиллагчдын 50-иас доошгүй хувь нь ХБИ-тэй ААН-д 20 хүртэлх сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг (эргэн төлөлттэй);
- ХБИ-ний ажилладаг ажлын байр хадгалах дэмжлэг;

4. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:

- Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох.

Санхүүгийн дэмжлэг хүссэн төслийг аймаг, дүүргийн ХХҮГ/Х-ийн ажилтан сонгон шалгаруулж, дэмжлэгийг үзүүлж, мөн эргэн төлөлтийг хариуцан ажилладаг. Одоогоор иргэн, ААН-ийн авсан санхүүгийн дэмжлэгийн хэмжээ, эргэн төлөлт зэрэг санхүүгийн дэмжлэгтэй холбоотой мэдээллийг Explorer, Талст гэсэн 2 программд бүртгэж байна.

Гэхдээ санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээний зохион байгуулалтыг сайжруулах зайлшгүй шаардлагатай байна. Санхүүгийн дэмжлэг авсан иргэн хугацаандаа эргэн төлөлт хийхгүй тохиолдолд энэ талаар Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүртгэдэггүй учраас санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт муу байх эрсдэл үүсдэг. ХХҮЕГ-ын мэдээгээр 2015 оноос хойш нийт 38 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг эргэн төлөгдөөгүй, шүүхийн маргаантай байна. Энэ нь санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт хариуцсан гэрээт хуульч ажиллуулахтай холбоотойгоор ХХҮЕГ-ын цалингийн сангийн зардлыг нэмэгдэх, өр авлагыг барагдуулах чиглэлээр ХХҮХ-ийн мэргэжилтнүүдийн ажлын ачаалал ихэсдэг.

ЗГ-аас 2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 5.13-14 дэх заалтуудад хувиараа хөдөлмөр эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагаанд шаардагдах богино хугацааны эргэлтийн хөрөнгийн санхүүгийн дэмжлэг болох барьцаагүй, хүүгүй, эргэн төлөгдөх нөхцөлтэй 1.0 сая хүртэл төгрөгийг санхүүгийн шинэ технологи (Fintech) ашиглан цахим хэлбэрээр дамжуулан олгож болох ба арга хэмжээг банк, санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа, тодорхой туршлага бүхий санхүүгийн байгууллагаар дамжуулан хэрэгжүүлнэ гэж шинээр заасан байна. Энэ зарчмыг мөн бусад санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагаанд ашиглаж орчин үеийн санхүүгийн цахим байгууллагууд болох **‘Simple’, ‘Pocket’, ‘Numur’** зэрэг байгууллагуудаар дамжуулан олгох боломжийг судлах шаардлагатай юм.


Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлттэй холбоотой тулгардаг асуудал нь дээр дурдсанчлан нэгжүүдийн тайланд их хэмжээний авлага бүртгэгдэх явдал юм. Их хэмжээний авлага бүртгэгдсэн ч эргэн төлөлт муу байх нь ХХҮГ/Х-үүдийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт хязгаарлалттай гарах үндсэн шалтгаан болдог байна.

Иймд санхүүгийн дэмжлэг үзүүлэх уг арга хэмжээний зохион байгуулалт, журмыг боловсронгуй болгох, хэрэгжилт хариуцсан хүний нөөцийн асуудлыг шийдэх эсхүл санхүүгийн цахим байгууллагууд, ББСБ зэрэг санхүүгийн мэргэжлийн байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

6. ДҮГНЭЛТ

- 1.** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулах, ХЭДС болон МБС-ыг дэмжих сангийн үйл ажиллагааны зохицуулалтыг сайжруулах, сангийн төсвийг төлөвлөх, хуваарилах болон хугацаандаа эргэн төлөөгүй санхүүгийн дэмжлэгийн өр, авлагыг хэрхэн барагдуулах талаар нарийвчилсан зохицуулалтуудыг холбогдох журамд тусгах шаардлагатай байна.
- 2.** Эдийн засгийн өсөлт, бууралт нь ажилгүйдлийн түвшинд нөлөөлөхгүй байгаа нь манай улсад бүтцийн ажилгүйдлийн түвшин өндөр байгааг илтгэж байна. Уул уурхай, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын өсөлт өндөр боловч ажиллах хүчний шингээлт бага, ихэнх ажиллагчид ХАА, үйлчилгээний салбарт ажиллаж байна.
- 3.** Хөдөлмөрийн зах зээлд дээд боловсролын ажил мэргэжлийн эрэлтээс илүү МБСБ-аар бэлтгэгддэг ажил мэргэжлийн эрэлт өндөр байна. Жишээ нь, тогооч, зөөгч, гагнуурчин г.м. Үүнд эдгээр ажил мэргэжил дэх хөдөлмөр эрхлэлт төдийлөн тогтвортой бус байдаг хүчин зүйл нөлөөлж байна.
- 4.** Нэг талаас жил бүр 100 гаруй мянган хүн ажилгүй байгаа боловч нөгөө талаас хөдөлмөрийн зах зээлд сүүлийн 10 жилийн хугацаанд жилд 57.6-80.1 мянган ажиллах хүчний эрэлт үүсч, сүүлийн 8 жилийн хугацаанд дунджаар 16.6 мянган ажиллах хүчний хомсдолд жил бүр орж, ажил олгогчид гадаадаас ур чадвартай ажиллах хүч импортолж байгаа нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт тохирохгүй зөрүүтэй байгааг илтгэж байна.
- 5.** МБСБ төгсөгчдийн зөвхөн 51 хувь нь эзэмшсэн мэргэжлийн дагуу хөдөлмөр эрхэлж байгаа нь их, дээд сургууль төгсөгчдийнхөөс (66.5%) доогуур үзүүлэлттэй байна.
- 6.** Жилд дунджаар 20 орчим мянган суралцагч МБСБ-ыг төгсдөг ба тэдний 63 орчим хувь нь ажлын байртай болж, 51 хувь нь мэргэжлээрээ ажиллана гэж тооцвол нийт төгсөгчийн 32 орчим хувь буюу дөнгөж 6.4 мянган төгсөгч нь мэргэжлээрээ ажиллах магадлалтай байна. Иймд МБС-ын чанарыг сайжруулж, зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжил, ур чадвар эзэмшүүлэх шаардлагатай байна. Иймд МБС-ын чанарыг сайжруулж, зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжил, ур чадвар эзэмшүүлэх шаардлагатай байна. Ялангуяа хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй байх ирээдүйн ажил мэргэжил болон ажил мэргэжлийн ирээдүйн өөрчлөлтийг МБС-ын хөтөлбөрт тусгадаг уян хатан тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.
- 7.** Хөдөлмөр, халамжийн салбарт нийт 1,700 орчим төрийн албан хаагч ажиллаж байгаагаас хөдөлмөр асуудал хариуцсан 260 орчим төрийн албан хаагч байна. Сум, хороонд ажиллаж байгаа нэг мэргэжилтэн нь нийгмийн халамж, хөдөлмөрийн асуудлыг давхар хариуцаж, ажлын цагийнхаа 80 хувийг халамжийн ажилд зориулж байна. 2000 оноос хойш хөдөлмөр, халамжийн байгууллагыг салгах, нэгтгэх бүтцийн өөрчлөлтийг хэд хэдэн удаа хэрэгжүүлснээс хүний нөөц тогтвор суурьшилгүй болсон. Цаашид хөдөлмөрийн салбарын мэргэжилтнүүдэд туршлага, ур чадвар эзэмшүүлэх, сургалтад хамруулах, дутагдалтай орон тоог нэмэгдүүлэх зэрэг асуудалд анхаарах шаардлагатай.

- 8.** Дүүргийн ХХҮХ-ийн Хөдөлмөр эрхлэлтийн албаны ажилтнууд ажлын цагийн ихэнхийг санхүүгийн дэмжлэг хүссэн иргэдийн хүсэлтийг хүлээн авах, сонгон шалгаруулалт хийх, иргэдэд ажилгүйдлийн тэтгэмж авах тодорхойлолт гаргаж өгөх зэрэг үйл ажиллагаанд зарцуулж, ажилгүй иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилд зуучлах үйлчилгээнд бага цаг зарцуулж байна. Энэ асуудлаар үйлчилгээ авахаар ирэх иргэдийн тоо ч цөөн байна.
- 9.** Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг ХХҮГ, хэлтэс болон эрх бүхий хөдөлмөрийн хувийн бирж, сургалтын байгууллагууд үзүүлж байна. Хувийн биржээр үйлчлүүлсэн иргэд нь ажил олгогчийн шаардсан ур чадварыг эзэмших, мэргэжлийн болон давтан сургалт, чадавхжуулах сургалтад хамрагдах хүсэлтэй байдаг ч хувийн биржүүдэд ийм төсөв олгодоггүй учир төлбөртэй сургалтыг санал болгох эсвэл харъяа дүүргийн ХХҮХ-т хандахыг зөвлөдөг байна.
- 10.** ХЭД хөтөлбөрүүд нь хөдөлмөрийн зах зээлд шууд нэвтрэхэд бэрхшээлтэй, удаан хугацааны сургалт, зөвлөгөө, арга хэмжээ шаардлагатай бүлэгт (ХБИ, залуучууд, ахмад настан, ядуу иргэн г.м) түлхүү чиглэжээ. Бүтцийн ажилгүйдэл, түр ажилгүйдэлд өртсөн, хөдөлмөр эрхлэлтийн дэмжлэг, нэмэлт үйлчилгээ авснаар хөдөлмөрийн зах зээлд оролцоход бэлэн ажил хайгчид чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ дутмаг байна.
- 11.** ХЭДС-ийн орлогын эх үүсвэрийн тогтворгүй байдлаас шалтгаалан ХЭД хөтөлбөрийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх бодит хугацаа 4-6 ба 9-12 сарууд гэсэн богино мөчлөгтэй байна. Гэтэл хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний эрэлтийн 70 гаруй хувь жилийн эхний хагаст бий болдог байна.
- 12.** Орон нутгийн ХХҮГ/Х-үүд өөрсдийн онцлогт нийцсэн, амжилттай хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн үр дүнг үнэлж, дараагийн төлөвлөлтөд тусгуулах талаар хангалттай идэвх зүтгэл гаргадаггүй.
- 13.** ААН, ажил олгогчийг дэмжих арга хэмжээг нэмэгдүүлэх, шинээр бий болгох хэрэгцээ өндөр байна. Ихэнх хөтөлбөрийн арга хэмжээ албан бус секторт ажиллагчид, иргэнд чиглэдэг учир ажилгүйдэл, ажиллах хүчний албан ёсны статистик тоонд нөлөөлөх нь бага учраас албан бус хөдөлмөр эрхлэлтийг бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.
- 14.** ХЭД хөтөлбөр, арга хэмжээ, үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо мэдээллийг хүйс, зарим тодорхой насны ангиллаар гаргаж мэдээлдэггүй учраас эдгээр хөтөлбөр нь жендэрийн ялгаа, тэгш бус байдлыг бий болгож буй эсэхэд дүгнэлт хийх боломжгүй байна.
- 15.** ХЭД хөтөлбөр, арга хэмжээ, үйлчилгээний тарифийн бодит үнэд өөрчлөлт оруулалгүй удсан, зарим нь зах зээлээс доогуур өртөгтэй байна.
- 16.** ХЭДС-ийн орлого нийт дүнгээр төлөвлөгөөнөөс давж биелдэг боловч орлого бүрдүүлэлт жилийн саруудад харилцан адилгүй. Сангийн орлогын гол эх үүсвэр болох гадаад иргэдийн ажлын байрны төлбөрийн орлого 3-4 дүгээр сараас эхлэн төвлөрч, 6, 9 дүгээр сард идэвхжин оны эцэст ажил олгогчид дараа оны ажлын байрны төлбөрийг урьдчилан төлдөг учраас 12 дугаар сард орлого өсдөг.
- 17.** ХЭДС-ийн сүүлийн 5 жилийн зарцуулалтыг харахад ХЭД хөтөлбөрүүдийн төсөв нь хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний төсвөөс 23.8 дахин илүү байна. Гэхдээ ХЭД хөтөлбөрт хамрагдсан хүний тоо, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамрагдсан хүний тооноос харьцангуй цөөн байна.

- 
- 18.** Сүүлийн 5 жилийн дунджаар харахад, ХЭД хөтөлбөрүүдийн нийт төсвийн 64-77 хувь нь зөвхөн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд, төсвийн 14.5-27 хувь нь нийтийг хамарсан ажилд, дөнгөж 3-7.5 хувь нь сургалтын арга хэмжээнд зарцуулагджээ.
- 19.** ХЭД сангийн нийт төсвийг УИХ-аас баталсны дараа ХЭҮЗ нь оны дараа хуралдаж, төсөв зарцуулах хөтөлбөр, арга хэмжээ, хуваарийг баталдаг нь хөтөлбөр хэрэгжиж эхлэх хугацаа, нэгжүүд хөтөлбөрт тулгуурласан санхүүжилтийг хүлээн авах хугацаа зэргийг удаашруулж байна. Иймд ХЭҮЗ оны өмнө буюу 11, 12 дугаар сард хуралдаж, хөтөлбөр, төсвийн хуваарийг батлах нь зүйтэй байна.
- 20.** ХЭД хөтөлбөр, арга хэмжээг батлахдаа тэдгээрийг хэрэгжүүлэх хүний нөөц, бүтэц орон тооны асуудлыг давхар шийдэж, цалин хөлс зардлыг төсөвтөө тусгах хэрэгтэй байна.
- 21.** Аймаг, дүүргийн ХХҮГ\Х-ийн төсвийн санал болон урьд оны төсвийн хуваарийг харгалзан ХЭДС-ийн төсвийг хуваарилах нь тухайн орон нутагт ХЭД үйлчилгээ, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг бодитой хуваарилах үндэс болохгүй байна. Орон нутгийн бодит хэрэгцээ, ажилгүйчүүдийн тоо, ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй өрх, иргэний тоо, ажиллагчдын тоо зэргийг харгалзан ХЭДС-ийн төсвийг хуваарилах тодорхой аргачлалтай болох шаардлагатай байна.
- 22.** ХЭД хөтөлбөрүүдийг жил бүр шинэчлэн баталдаг учраас хөтөлбөрийн тогтворгүй байдал нь зарим арга хэмжээг үр дүнгүй болгох эрсдэлтэй байна. Иймд тогтвортой үр дүнтэй хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн хэрэгжих хугацааг уртасгах, ихэнх хөтөлбөрт багтдаг байнга хэрэгждэг арга хэмжээнүүдийг хөтөлбөрөөс салгаж, байнгын арга хэмжээ болгон төсөв хуваарилдаг болох. Хөтөлбөр арга хэмжээний агуулга, давхардал, хийдлийн асуудлыг бодлогын зөвлөхүүд цаашид судлах юм.
- 23.** Оны эхний улиралд ХЭДС-ийн орлогын гол үүсвэр нь сангийн урьд оны үлдэгдэл болдог. Урьд оны үлдэгдлийг санд байршуулах санхүүжилтийн эрхийг оны эхний сард багтаан нээлгэдэг болох асуудлыг СЯ-тай зөвшилцөн шийдвэрлэх шаардлагатай байна.
- 24.** НХЭГ, аймаг, дүүргийн ХХҮХ-үүдэд санхүүжилтийг төрийн сангийн нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан олгодог. Энэ нь төрийн сангийн гүйлгээний тогтолцооноос хамаарч санхүүжилт удаашрах, сангийн тайлан мэдээ гаргах, нэгтгэхэд заавал нэмэлт тохируулга шаардах болдог. Иймд үндсэн дансаар санхүүжилт хийх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.
- 25.** ХЭД хөтөлбөрүүдийн хүрээнд үзүүлдэг хүүгүй, барьцаагүй санхүүгийн дэмжлэг нь хамгийн эрэлттэй арга хэмжээ болдог байна. Эргэн төлөгдөөгүй санхүүгийн дэмжлэгтэй холбоотой үүсэх өр, авлагыг барагдуулах журмыг тодорхой болгох, хэрэгжилт хариуцсан хүний нөөцийн асуудлыг шийдэх эсхүл ББСБ зэрэг санхүүгийн байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх зэргээр уг арга хэмжээний зохион байгуулалтыг сайжруулах шаардлагатай байна.



7

ЗӨВЛӨМЖ

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦООНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ ҮЗЭЭД ЗӨВЛӨХ БАГ НЬ ДАРААХ ГОЛ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА. ҮҮНД:

Зөвлөмж 1.

ХЭД хөтөлбөрийн тоо 5-7 байгааг цөөлөх. Тогтвортой хэрэгждэг арга хэмжээнүүдийг хөтөлбөрөөс салгаж төлөвлөдөг болох. 2012-2021 онд хэрэгжүүлсэн ХЭД бүх хөтөлбөрийн хэрэгжилтэд зөвлөх баг нь үнэлгээ хийж, энэ тухай тусдаа тайлан боловсруулсан. Энэхүү тайланд үндэслэн, ХЭДС-ийн төсвийн төлөвлөлтөд тусгах байнгын арга хэмжээ тодорхойлох. Тухайлбал, ХЭД хөтөлбөрийн нийт төсвийн 64-77 хувь зөвхөнганцарга хэмжээнд буюу санхүүгийн дэмжлэгт зарцуулагддаг учраас уг арга хэмжээнд нэгдсэн төсөв тавьж, төлөвлөх тохиолдолд хэрэгжилтийн шат дамжлага багасна. Хөтөлбөрийн тоог багасгахдаа Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг бие даасан хөтөлбөр байхаар төлөвлөж, хөрөнгийг төсөвлөх.

Зөвлөмж 2.

ХЭД нийтлэг үйлчилгээний чанар, стандартыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, санхүүжилтийг өсгөх. Аймаг, нийслэл, дүүргийн ХХҮГ\Х-үүд нь иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх, АМЧБ олгох, ажилд зуучлах зэрэг нийтлэг үйлчилгээг нэр төдий хэрэгжүүлж, ХЭД хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний төсөл, хөтөлбөр шалгаруулахад ихэнх цагаа зарцуулдаг учраас ажилгүйдлийг бууруулах зорилтоо хангаж чадахгүй байна.

Зөвлөмж 3.

ХЭД үйл ажиллагааг иргэн төвтэй үйлчилгээнд шилжүүлэхийн тулд ХХҮГ\Х-ийн одоогийн ХЭХ\А-ны ажилтнуудын чиг үүрэг, орон тоог шинэчлэн зохион байгуулах. Ажилтнуудын чиг үүргийг 1) ажилгүй иргэдийн нөхцөл байдал, ур чадварыг үнэлэх, 2) хэрэгцээнд нь нийцсэн үйлчилгээ, хөтөлбөр, арга хэмжээнд хамруулах, 3) ажлын байранд зуучлах гэсэн үндсэн үйл ажиллагаанд чиглүүлэх. Шаардлагатай бол ХХҮГ\Х дотроо зохион байгуулалт хийх замаар хүний нөөцийг нэмэгдүүлэх. Чадавхи сайжруулах сургалтуудыг зохион байгуулах.

Зөвлөмж 4.

ХЭД хөтөлбөрийн дизайн, хамрах хүрээ, зорилтот бүлгийг тодорхойлохдоо тооцоо, судалгаа, орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал, онцлогт үндэслэдэг болох. Хөтөлбөр, арга хэмжээг дүүрэг, орон нутгийн онцлогт тохируулан уян хатан төлөвлөж, шаардлагатай өөрчлөлтийг тухай бүр оруулахгүй байна. Тухайлбал, алслагдмал орон нутгийн залуучууд, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ дутмаг байна.

Зөвлөмж 5.

ХЭД хөтөлбөр, арга хэмжээ, үйлчилгээнд хамрагдсан иргэдийн мэдээлэл, хөтөлбөр, үйлчилгээний үр дүнд ажилтай болсон хүний тоог хүйс, зарим шаардлагатай насны ангиллаар тайлагнадаг болох.

Хөтөлбөр, арга хэмжээ, үйлчилгээ нь хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн ялгааг бууруулахад чиглэж, тэгш бус байдлыг гүнзгийрүүлэхгүй байхад хувь нэмэр оруулж байгаа эсэхийг дүгнэх боломжгүй байна. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөрийн зах зээл дэх оролцоог нэмэгдүүлэхэд тэдний хэрэгцээнд нийцсэн хөтөлбөр зайлшгүй шаардлагатай юм.

Зөвлөмж 6.

ХЭД хөтөлбөр, арга хэмжээ, нийтлэг үйлчилгээг хэрэгжүүлэхэд оролцдог хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний чанарыг сайжруулах. Хувийн биржүүд, сургалтын байгууллагууд зэрэг хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагаанд тавих чанарын хяналт хангалтгүй, хамтын ажиллагаа сул хөгжсөн, тэдний чадавхыг бэхжүүлэхэд төрийн байгууллагуудаас дэмжлэг үзүүлдэггүй. Хувийн хэвшлийн байгууллагын гүйцэтгэсэн арга хэмжээ, үйлчилгээнд олгох санхүүжилтийг цаг хугацаанд нь олгодоггүй, зах зээлийн өртгөөс доогуур үнэлгээтэй тарифаар санхүүжүүлдэг нь үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж байна

Зөвлөмж 7.

ХЭД үйлчилгээ, хөтөлбөрийн үйл ажиллагааг оны эхнээс эхлүүлж, жилийн турш тогтмол хэрэгжүүлдэг болох. ХЭД сангийн төсвийг УИХ-аас баталсны дараа ХЭҮЗ нь оны дараа хуралдаж, төсөв зарцуулах хөтөлбөр, арга хэмжээ, хуваарийг баталдаг учраас ХХҮГ\Х-үүд санхүүжилтээ авч чадахгүйд хүрч, үйл ажиллагаа нь 4 дүгээр сарыг хүртэл зогсонги байдалтай байдаг. Гэтэл хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний эрэлтийн 70 гаруй хувь жилийн эхний хагаст бий болдог байна. Иймд ХЭҮЗ-ийг оны өмнө буюу 11.15- 12.25-ны хооронд хуралдаж дараа онд хэрэгжүүлэх ХЭД хөтөлбөр, төсвийн хуваарийг батлах цагалбарыг холбогдох хууль тогтоомжид оруулах. Дараа онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний заавар, журмыг оноос өмнө баталж, харьяа нэгжүүдэд хүргүүлж хэвших.

Зөвлөмж 8.

ХЭДС-ийн төсвийн төслийг боловсруулахдаа аймаг, дүүргийн бодит хэрэгцээнд тулгуурлан үндэслэлтэй төсөвлөдөг болох. ХЭДС-ийн төсвийг аймаг, дүүргийн ХХҮГ\Х-т харилцан адилгүй хуваарилж байна. Тухайн аймаг, дүүргийн бодит хэрэгцээ шаардлага, ажилгүйчүүдийн тоо, ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй өрх, иргэний тоо, ажиллагчдын тоо зэргийг харгалзан ХЭДС-ийн төсвийг оновчтой хуваарилах аргачлал бий болгож, мөрдөх.

Зөвлөмж 9.

НХЭГ, аймаг, дүүргийн ХХҮГ\Х-үүдэд хуваарилсан төсвийг үйл ажиллагааны үр дүнд үндэслэн гүйцэтгэлээр тогтмол санхүүжилдэг болох. Үйлчилгээ үзүүлсэн болон ажлын байранд зуучилсан хүний тоо зэрэг чанарын үзүүлэлтэд үндэслэн ХХҮГ\Х-үүдийн санхүүжилтийг нэмэгдүүлж, хорогдуулдаг байх уян хатан зохицуулалтыг бий болгох. Ингэхдээ ХХҮГ\Х-ээс хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ажлын дадлага туршлагагүй залуучуудыг ажилд зуучлан оруулсан тохиолдолд зардлыг өсгөн тооцож, санхүүжилтийг олгодог болох.

Зөвлөмж 10.

ХЭДС-ийн санхүүжилтийг төрийн сан дахь үндсэн дансаар хийх нөхцөлийг бүрдүүлэх. НХЭГ, аймаг, дүүргийн ХХҮХ-үүдэд санхүүжилтийг төрийн сангийн нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан олгож байгаа нь санхүүжилт удаашрах, сангийн тайлан мэдээ гаргах, нэгтгэхэд заавал нэмэлт тохируулга шаардаж байна.

Зөвлөмж 11.

Эргэн төлөгдөөгүй санхүүгийн дэмжлэгтэй холбоотой үүссэн өр, авлагыг барагдуулах зохицуулалтыг журамлах, хэрэгжилт хариуцсан хүний нөөцийн асуудлыг шийдэх. Өнөөг хүртэл хуримтлагдсан 36 тэрбум төгрөгийн өрийг барагдуулах чиглэлээр цогц арга хэмжээ хэрэгжүүлэх. Цаашид цахим санхүүгийн байгууллага эсхүл ББСБ зэрэг мэргэжлийн байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх асуудлыг судалж, шийдвэрлэх.



8.

УУЛЗАЛТ, ЯРИЛЦЛАГА ХИЙСЭН ХҮМҮҮСИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

- СЯ-ны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн дарга **М.Санжаадорж**
- ХНХЯ-ны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга **С.Дамбий**, мөн газарт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төлөвлөлт, санхүүгийн дэмжлэг хариуцсан шинжээч **Ш.Гэрэлцэцэг**
- ХНХЯ-ны Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга **А.Халиунаа**
- ХНХЯ-ны Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг дэмжих хэлтсийн дарга **Б.Алтантулга**
- ХНХЯ-ны Халамжийн сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, төсвийн нэгдсэн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч **Б.Алтанцэцэг**
- ХНХЯ-ны Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч, ахлах шинжээч **Ц.Эрдэнэтөгс**
- Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын төсөв, санхүүжилт хариуцсан мэргэжилтэн **Б.Батцэцэг**
- СЯ-ны Төрийн сангийн газрын мэргэжилтэн **Ч.Цэдэндорж, М.Алтанхорол**
- СЯ-ны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн **Ж.Төгөлдөр**
- Швейцарын Хөгжлийн Агентлагийн “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн зохицуулагч **Т.Энхтуяа**
- ХХҮЕГ-ын Санхүү, төлөвлөлтийн газрын дарга **Б.Цэрэндаваа**
- ХХҮЕГ-ын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газрын ахлах мэргэжилтэн **Т.Лхагвасүрэн**

- ХХҮЕГ-ын Санхүү төлөвлөлтийн газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан хариуцсан ахлах мэргэжилтэн **Б. Мөнгөнцэцэг**
- Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газрын дарга **С.Нямдорж**
- НХЭГ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга **Н.Мөнхгэрэл**
- Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газрын ахлах мэргэжилтэн **Н.Одонтуяа**
- Чингэлтэй дүүргийн ХХҮХ-ийн дарга **А.Сэрээтэр**
- Чингэлтэй дүүргийн ХХҮХ-ийн Хөдөлмөр эрхлэлтийн албаны дарга **Д.Одгэрэл**, Төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн **П.Ганцэцэг**
- Баянзүрх дүүргийн ХХҮХ-ийн Хөдөлмөр эрхлэлтийн албаны дарга **Д.Нямаа**
- Баянгол дүүргийн ХХҮХ-ийн Хөдөлмөр эрхлэлтийн албаны дарга **Д.Уянга**
- Хан-Уул дүүргийн ХХҮХ-ийн Хөдөлмөр эрхлэлтийн албаны дарга **Б.Алтанцэцэг**
- Сонгинохайрхан дүүргийн ХХҮХ-ийн Хөдөлмөр эрхлэлтийн албаны дарга **С.Уугантуяа**
- Сүхбаатар дүүргийн ХХҮХ-ийн Хөдөлмөр эрхлэлтийн албаны дарга **Д.Батдулам**
- Налайх дүүргийн ХХҮХ-ийн Хөдөлмөр эрхлэлтийн албаны дарга **Т.Уянга** (утсаар хийсэн ярилцлага)
- Багануур дүүргийн ХХҮХ-ийн хөдөлмөр эрхлэлтийн албаны дарга **Ч.Одмандах** (утсаар хийсэн ярилцлага)
- Сэлэнгэ аймгийн ХХҮГ-ын Хөдөлмөрийн эрхлэлтийн хэлтсийн дарга **Б.Ганцолмон** (утсаар хийсэн ярилцлага)
- Хөвсгөл аймгийн ХХҮГ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга **н.Мөнхжаргал** (утсаар хийсэн ярилцлага)
- Төв аймгийн ХХҮГ-ын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөл хариуцсан мэргэжилтэн **Д.Оюундэлгэр** (утсаар хийсэн ярилцлага)
- Баянхонгор аймгийн ХХҮГ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга **Ж.Өлзийжаргал** (утсаар хийсэн ярилцлага)
- Монголын Хөдөлмөрийн биржүүдийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал **А.Амаржаргал**
- “Инноваци ба Ирээдүйн ажлын байр 2021” сэдэвт хэлэлцүүлэг

9.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Веб сайт:

www.legalinfo.mn

www.1212.mn

www.ilo.org

Хууль, тогтоомж, бодлого, журам:

1. “Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой Хөдөлмөрийн тухай” хууль, **(1999, 2021 он)**
2. “Ажиллах хүч, гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хууль, **(2001 он)**
3. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хууль, **(2011 он)**
4. “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хууль, **(2002 он)**
5. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хууль, **(2008 он)**
6. “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”, **(МУ-ын ЗГ-ын 2016 оны 320 дугаар тогтоол)**
7. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, **(УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол)**
8. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам” **(ЗГ-ын 2011 оны 375 дугаар тогтоол)**
9. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”, **(ЗГ-ын 2021 оны 340 дүгээр тогтоол)**
10. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, **(Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/96 тоот тушаал)**
11. “Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт (тарифаар тооцож) олгох журам”, **(Хөдөлмөрийн сайдын 2014 оны А/123 тоот тушаал)**
12. “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”, **(ЗГ ын 2011 оны 117-р тогтоол)**
13. “Зардлын дундаж норматив батлах тухай” журам, **(ЗГ-ын 2012 оны 94-р тогтоол)**
14. “Хувьсах зардлын дундаж норматив, санхүүжүүлэх аргачлал батлах тухай” журам, **(ЗГ-ын 2016 оны 276 дугаар тогтоол)**

15. “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, албан хаагчдад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох журам”, **(ЗГ-ын 2017 оны 346 дугаар тогтоол)**
16. ХЭҮЗ, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг батлах тухай” тогтоол, **(2012-2022 он)**

Судалгаа, тайлан:

1. ҮСХ, “Ажиллах хүчний судалгаа”, **(2021 оны II улирал)**
2. ХНХСИ, “ХЗЗ-н эрэлтийн барометрийн судалгааны тайлан”, **(2019 он)**
3. ХНХСИ, “ХЗЗ-н эрэлтийн барометрийн судалгааны тайлан”, **(2020 он)**
4. ILO-OECD, “The impact of the COVID-19 pandemic on jobs and incomes in G20 economies” paper, **(2020)**
5. СЯ, “Засгийн газрын зүгээс Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай” тайлан, **(2021 он)**
6. ХНХСИ, “МУ-ын Хөдөлмөрийн зах зээл дэх “Ковид-19” цар тахлын нөлөө”, **(2021 оны III улирал)**
7. ХНХСИ, “Хөдөлмөрийн зах зээлийн тойм”, **(2021 оны II улирал)**
8. ХХҮЕГ, Байгууллагын хүний нөөцийн мэдээлэл, **(2020 он)**
9. “United Nations Educational, Scientific and Cultural Organization. Handbook on career counselling a practical manual for developing, implementing and assessing career counselling services in higher education settings, Paris”, **(2002)**
10. OECD ба Европын Комисс: Ажил мэргэжлийн чиг баримжаа: “Бодлого боловсруулагчдад зориулсан гарын авлага”, хуудас 10, **(OECD/Европын Комисс, Парис, 2004)**
11. Д.Нармандах, Вульф Шмайдер, “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх төв байгуулахад баримтлах зөвлөмж” гарын авлага, **(2016 он)**
12. Г.Түмэннаст, М.Шарпф, Йо. Эртельт, “Ажил мэргэжлийн чиг баримжаа”, хуудас 14, **(2018 он)**
13. ДБ-ны санхүүгийн дэмжлэгээр хэрэгжиж буй “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн зөвлөхүүдийн тайлан, **(2021 он)**
14. Селин Ферре, “Монгол улсын хөдөлмөрийн зах зээлийн үйлчилгээ, хөтөлбөр”, хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээний үнэлгээний тайлан, **(2020 он)**

10.

ХАВСРАЛТ

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖИШИГ ЗАРДАЛ

Зардлын хэмжээг жишиг болгох арга хэмжээнүүд		Одоогийн тариф		Санал болгож буй тариф	
Нэг. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх					
1.1	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний нэг хүнд ногдох зардлын дээд хэмжээ /мян. төг/	Ганцаарчилсан	12.0	Ганцаарчилсан	18.0
		Бүлгээр	6.0	Бүлгээр	13.0
1.2	Ажилд зуучлах үйлчилгээний нэг хүнд ногдох зардлын дээд хэмжээ /мян.төг/	7.0		7.0	
Хоёр. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээ					
2.1 Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр					
2.1.1	Зөөлөн ур чадварын сургалтын нэг хүнд ногдох зардлын дээд хэмжээ /мян.төг/	Ажлын байрны харилцаа, сэтгэл зүйн сургалтын нэг хүнд ногдох зардлын дээд хэмжээ 30.0 мянган төгрөг		Одоогийн мэдээллийн хүрээнд өртөг тооцох боломжгүй. Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээ мэдээлэл арга зүйн төвөөс гаргасан хөтөлбөртэй танилцах, хэрэгжүүлэгч байгууллагуудаас мэдээлэл цуглуулах шаардлагатай.	
2.1.2	Мэргэжлийн (онолын) сургалтын нэг хүнд ногдох дээд хэмжээ /мян.төг/				
2.1.3	Чиглүүлэгчтэй ажлын байран дээрх дагалдан сургалтын нэг хүнд ногдох дээд хэмжээ /мян. төг/	-		Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцон 12 сараар	
2.1.4	Хувь хүний бэлтгэлийг хангах арга хэмжээний нэг хүнд ногдох дээд хэмжээ /мян.төг/	50.0		32.0	

2.2 Аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр							
2.2.1	Аж ахуй эрхлэлтийн сургалтын нэг хүнд ногдох зардлын дээд хэмжээ /мян.төг/	3 өдөр = 30.0			3 өдөр = 45.0		
2.2.2	Улаанбаатар хотоос хөдөөд шилжин суурьшиж, мал маллах өрхийн орон нутагруу нүүхэд олгох нэг удаагийн санхүүгийн дэмжлэг	50-200 км	201-350 км	351-500 км	50-200 км	201-350 км	351-500 км
		150.0	350.0	500.0	150.0	350.0	500.0
2.2.3	Мал маллах арга ухааны сургалт зохион байгуулах зардлын жишиг хэмжээ /мян.төг/	1 цаг = 3.5			1 цаг = 3.5		
2.2.4	Борлуулалтын цэг ажиллуулахад зарцуулах нэг сарын зардлын дээд хэмжээ /мян.төг/	Улаанбаатар хот	Аймгийн төв	Сумын төв	Улаанбаатар хот	Аймгийн төв	Сумын төв
		700.0	600.0	400.0	700.0	600.0	400.0
2.3 Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр							
2.3.1	Аймаг, дүүргийн хэмжээнд шалгарсан шилдэг "Старт-Ап" залуу, эсхүл залуучуудын багт олгох санхүүгийн дэмжлэг /сая. төг/	10.0			10.0		
2.3.2	Улсын хэмжээнд шалгарсан шилдэг "Старт-Ап" залуу, эсхүл залуучуудын багт олгох санхүүгийн дэмжлэг /сая.төг/	1-р байр	2-р байр	3-р байр	1-р байр	2-р байр	3-р байр
		20.0	17.0	13.0	20.0	17.0	13.0
2.4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр							
2.4.1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн зах зээл дээр ажиллуулах дэмжлэгтэй хөдөлмөр эрхлэлтийн цогц арга хэмжээний жишиг зардал /сая. төг/	-			Нэг ажлын байранд – 10.0		
2.4.2	Аж ахуй эрхлэлтийн сургалтын нэг хүнд ногдох зардлын дээд хэмжээ /мян.төг/	3 өдөр = 40.0			3 өдөр = 59.5		
2.5 Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр							
2.5.1	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний зардлын хэмжээ /мян.төг/	1 цаг – 3.5			1 цаг – 3.5		

2.6 Ногоон ажлын байр хөтөлбөр

2.6.1	Мод тарих, арчлах, хамгаалах арга хэмжээний жишиг зардал / мян.төг/	-	Тарьсан модны тоо, ажилласан өдрөөр тооцон нийтийг хамарсан ажлын зардлын жишгээр ажлын хөлсийг бодож олгох ба тарьсан модоо арчлан хамгаалан, ургуулсан бол модны амьдралтын хувиар тооцон нэмэгдэл урамшуулал тооцон олгоно.
2.6.2	Нийтийг хамарсан ажил зохион байгуулах зардлын хэмжээ /мян. төг/	1 цаг – 3.5	1 цаг – 3.5

2.7 Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

2.7.1	Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдах нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын хэмжээ /мян.төг/	-	Нийслэлд	Аймгийн төвд	Аймгийн төвөөс бусад сумд
			13.7	15.0	16.7
2.7.2	Богино хугацааны ур чадвар олгох сургалт	-	Одоогийн мэдээллийн хүрээнд өртөг тооцох боломжгүй. Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээ мэдээлэл арга зүйн төвөөс гаргасан хөтөлбөртэй танилцах, хэрэгжүүлэгч байгууллагуудаас мэдээлэл цуглуулах шаардлагатай.		

